# “ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС УЧИРСАН ХОХИРЛЫГ ТӨРӨӨС НӨХӨН ТӨЛҮҮЛЭХ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ БОЛОВСРУУЛАХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН СУДЛАХ” СУДАЛГААНЫ АЖЛЫН ТАЙЛАН



Улаанбаатар хот

2019 он

**Судалгааны захиалагч:**

Хууль зүй, дотоод хэргийн яам

**Судалгааны багийн ахлагч:**

| | |
|---|---|
| Б.Галбадрах | Дотоод хэргийн их сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн Шийдвэр гүйцэтгэлийн тэнхимийн эрхлэгч, Хууль зүйн доктор /Ph.D/ |

**Судалгааны багийн гишүүд**

| | |
|---|---|
| Б.Алтангэрэл | Дотоод хэргийн их сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын төвийн эрхлэгч, Хууль зүйн доктор /Ph.D/, дэд профессор |
| Г.Хосбаяр | Дотоод хэргийн их сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн Харуул хамгаалалт, гүйцэтгэх ажлын тэнхимийн ахлах багш, Хууль зүйн магистр |
| Э.Өнөболд | Мөн тэнхимийн багш, Хууль зүйн магистр |

**Судалгааг хянасан:**

| | |
|---|---|
| Б.Батболд | Дотоод хэргийн их сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн захирал, Удирдахуйн ухааны магистр |

Агуулга

Товчилсон үг.

Зураг, хүснэгтийн жагсаалт

Ерөнхий мэдээлэл

Урьдчилан тандан судлах үнэлгээний тайлан

1.1 Асуудалд дүн шинжилгээ хийсэн байдал

1.1. Асуудлын мөн чанар, цар хүрээг тодорхойлсон байдал

1.2. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэдийг тодорхойлох:

1.3. Асуудлыг үүсгэж буй шалтгаан нөхцөл:

1.2 Асуудлыг шийдвэрлэх зорилтыг тодорхойлсон байдал

1.3 Асуудлыг зохицуулах хувилбарууд, тэдгээрийн эерэг, сөрөг талыг харьцуулсан байдал

1.4 Зохицуулалтын хувилбаруудын үр нөлөөг тандан судалсан байдал

1.5 Зохицуулалтын хувилбаруудыг харьцуулсан дүгнэлт

1.6 Олон улсын болон бусад улсын хууль эрх зүйн зохицуулалттай харьцуулсан байдал

1.7 Зөвлөмж

Хавсралт

Товчилсон үгийн жагсаалт:

| | |
|---|---|
| НҮБ | Нэгдсэн Үндэстний байгууллага |
| ЗГ | Засгийн газар |
| УИХ | Улсын Их Хурал |
| ХЗДХС | Хууль зүй, дотоод хэргийн сайд |
| ШШГЕГ | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар |
| ҮСХ | Үндэсний статистикийн хороо |
| ХСИС | Хууль сахиулахын их сургууль /ДХИС/ |
| ДНБ | Дотоодын нийт бүтээгдэхүүн |
| ГХХ | Гэмт хэргийн хохирол |
| Г/Х | Гүйцэтгэх хуудас |
| АНУ | Америкийн Нэгдсэн Улс |
| ХБНГУ | Холбооны Бүгд Найрамдах Герман Улс |
| ИБУИНВУ | Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улс |
| ОХУ | Оросын Холбооны Улс |

Зураг, хүснэгтийн жагсаалт


Зураг 1. Улсын хэмжээнд тухайн жилд бүртгэгдсэн болон шүүхээр шийтгүүлсэн гэмт хэргийн дүн.

Зураг 2. Гэмт хэргийн улмаас улсад учирсан хохирлын дүн

Зураг 3. Улсын хэмжээнд учирсан хохирол, иргэнд учирсан хохирлын дүн

Зураг 4. Гэмт хэргийн улмаас нийт хохирсон иргэний тоо

Зураг 5. Нийт учирсан хохирлын дүн болон нөхөн төлөгдсөн хохирлын дүн

Зураг 6. Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд барагдуулсан хувь

Зураг 7. Нийт учирсан хохирлын дүн болон нөхөн төлөгдсөн хохирлын дүн

Зураг 8. Ял шийтгүүлсэн хүмүүсийн боловсролын байдал

Зураг 9. Ял шийтгүүлсэн хүмүүсийн хөдөлмөр эрхлэлтийн байдал

Зураг 10. ЗГ-ын тусгай сангийн тухай хуульд тусгасан гэмт хэргийн 2019 онд үйлдэгдсэн байдал

Зураг 11. Эрүүгийн хуульд заасан 59 төрлийн гэмт хэргээс зонхилон үйлдэгдэж буй 6 гэмт хэргийн 2019 онд бүртгэгдсэн байдал

Хүснэгт 1. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн харьцуулалт

Хүснэгт 2. Засгийн газрын тусгай сангийнГэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангаас нөхөн төлбөр олгосон байдал.

Хүснэгт 3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас 2017-2019 онд гүйцэтгэсэн эрүүгийн хэргийн шийдвэртэй хохирол барагдуулах ажиллагааны гүйцэтгэлийн дүн мэдээ

Хүснэгт 4. Асуудлыг зохицуулах хувилбарууд, тэдгээрийн эерэг, сөрөг талыг харьцуулсан байдал

**Ерөнхий мэдээлэл:**

Нэгдсэн Үндэстний Байгууллагаас батлан гаргасан “Хүний эрхийн түгээмэл тунхаглал”,“Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт”, “Монгол Улсын Үндсэн хууль” болон бусад хууль тогтоомжуудад хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөний улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, сэргээн эдлүүлэх үүргийг төр иргэнийхээ өмнө хуулиар хүлээсэн байдаг.

НҮБ-ын Ерөнхий ассамблейн 1985 оны 40/34 дүгээр тогтоолоор "Гэмт хэрэг болон албан тушаалын байдлаа урвуулан ашигласны улмаас хохирогчдын талаарх хууль цаазын үндсэн зарчмын тухай тунхаглал"(Declaration of Basic Principles of Justice for Victims of Crime and Abuse of Power) батлагдсан нь дэлхийн улс орнуудадөөр өөрсдийн онцлогт тохирсон хохирогч судлалын бодлогыг боловсруулж хэрэгжүүлэхэрх зүйн гол үндэслэл болсон байна[1].

Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 8 дугаар зүйл, НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1985 оны 40/34 дүгээр тогтоолоор баталсан "Эрх мэдлээ урвуулан ашигласан болон гэмт хэргийн хохирогчийн талаарх шүүн таслах ажиллагааны үндсэн зарчмуудын тухай” тунхаглал, 2005 онд баталсан "Олон улсын хүний эрхийн эрх зүйн их хэмжээний зөрчил, хүмүүнлэгийн эрх зүйн ноцтой зөрчлийн улмаас хохирсон этгээдийн хохирлоо нөхөн төлүүлэх эрхийн талаарх үндсэн зарчмууд”, Гэмт хэргийн болон эрх мэдлээ урвуулан ашигласны улмаас хохирсон хүмүүсийн эрх зүйн хамгаалалтыг хангах үндсэн зарчмуудын 3.3-т "Төрийн албан тушаалтан болон төрийг төлөөлж албан үүрэг гүйцэтгэж буй этгээд үндэснийхээ хууль тогтоомжийг зөрчиж, эрх мэдлээ урвуулан болон хэтрүүлэн ашигласан бол хохирогч төрөөс нөхөн төлбөр авах эрхтэй байна. Тухайн хохирлыг хариуцах Засгийн газар нь өөрчлөгдсөн тохиолдолд тухайн асуудлыг хариуцах байгууллага хохирлыг барагдуулна” гэж хохирол нөхөн төлүүлэх эрхийг баталгаажуулсан байна.

Нэгдсэн Үндэстний Байгууллагаас батлан гаргасан дээрх баримт бичгүүдэд зааснаар буруутай этгээд нь хохирогч, түүний гэр бүл, асрамжинд байсан хүмүүст учруулсан хохирлыг шударгаар арилгах, хохирлоо нөхөн төлүүлэх эрхийг баталгаажуулах, төрөөс хохирогчийн бие махбод, сэтгэл санаа, зан суртахуунд учирсан хохирол, ажил хөдөлмөр, сургууль боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээ зэрэг алдагдсан нөхцөл, бодит болон бий болох орлого, хууль зүй, сэтгэл зүй, эмнэлэг, нийгмийн үйлчилгээний зардлыг бүрэн, шуурхай барагдуулах нөхцөл бололцоогоор хангах, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэхийг оролцогч улсуудад зөвлөхийн зэрэгцээ хэрэгжүүлж ажиллахыг шаарддаг.

Түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт "Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх эрхтэй” гэж заасан бөгөөд бусдын хууль бус үйлдлийн улмаас учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхтэй холбоотой асуудлыг Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний хууль болон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хуулийн холбогдох заалтуудаар зохицуулсан байдаг.

[1] https://legal.un.org/avl/ha/dbpjvcap/dbpjvcap.html

## УРЬДЧИЛАН ТАНДАН СУДЛАХ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

“Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг төрөөс нөхөн төлүүлэх хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах” судалгааг Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын /цаашид Аргачлал гэх/ 2.1-д заасас үе шатын дагуу хийж гүйцэтгэлээ[2].

## НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ

Үндэсний хууль тогтоомжуудад хохирогчийн эрхийн байдлыг дараах байдлаар хуульчилсан байна. Үүнд:

1. Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх… эрхтэй”, 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна[3]”,

2. “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль”-ийн 8 дугаар зүйлийн 8.1.1-т “Гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг хохирогч гэнэ” гэж тодорхойлоод мөн хуулийн 8.2 дугаар зүйлийн 1.9 дэх хэсэгт “гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийг нэхэмжлэх, нөхөн төлүүлэх хүсэлт гаргах” эрхтэй[4],

3. Мөн хуулийн 8.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Гэмт хэргийн улмаас учирсан эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирлыг нөхөн төлүүлэх, сэргээлгэхээр шаардлага тавьж байгаа хүн, хуулийн этгээдийг иргэний нэхэмжлэгч гэнэ”, 8.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Гэмт хэргийн улмаас эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээд нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, эсхүл түүний учруулсан эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирлыг хариуцвал зохих этгээдэд холбогдуулан иргэний нэхэмжлэл гаргах эрхтэй бөгөөд тэрхүү нэхэмжлэлийг шүүх уг хэргийн хамт хянан шийдвэрлэнэ”,

4. “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль”-ийн 3 дугаар зүйлийн 3.1-т “Монгол Улсын хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлоо зөрчигдсөн гэж үзэж байгаа аливаа этгээд уг эрхээ хамгаалуулахаар энэ хуульд заасан журмын дагуу шүүхэд нэхэмжлэл, хүсэлт, гомдол гаргах хэлбэрээр мэдүүлэх эрхтэй” гэж тус тус хуульчилсан[5].

5. Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.4.8-т “Төрөөс гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх бодлогын баримт бичгийг баталж, гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг бууруулах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлнэ” гэж тус тус заасан.

Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй дээрх эрх зүйн актуудаар нэр төр, алдар хүнд, санаа сэтгэл, бие эрхтэн, эд хөрөнгийн хохирол хүлээсэн

---

[2]Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт.
[3]Монгол Улсын Үндсэн хууль // Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1992. №1.
[4]Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль // Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2017. №23.
[5]Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль // Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2002. №8.

этгээдийг хохирогч, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн этгээдийг иргэний нэхэмжлэгч гэж тодорхойлсон нь үндсэндээ эд хөрөнгийн хохирлоос гадна эд хөрөнгийн бус хохирол нөхөн төлүүлэх эрхийг бататган хуульчилсан бөгөөд ийнхүү гэмт хэргийн улмаас хохирсон этгээдийн эдийн болон эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх эрхийг бататгасан нь эрх зүйн орчин бүрдсэн.

Нийгмийн хөгжлийн шалгуур үзүүлэлтүүдийн нэг нь тухайн нийгмийн гишүүд аливаа хууль бус үйл ажиллагаанаас хохирох эрсдлээс баттай хамгаалагдсан байх явдал юм.

Гэмт хэрэг бол өөрөө нийгмийн амьдралын сөрөг үр дагавар бөгөөд улс орны эдийн засаг доройтож ажилгүйдэл, ядуурал нэмэгдэж, үнэ, инфляци өсөхийн хирээр гэмт хэргийн гаралт ч бас нэмэгдэж байдаг зүй тогтолтой. Сүүлийн жилүүдэд гэмт хэрэг өсөхийн хирээр гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчийн тоо ч нэмэгдсээр байна.

Тэгвэл Монгол Улсын хувьд:

“Засгийн газрын тусгай сангийн тухай хууль”-ийн 10 дугаар зүйлийн 10.2-т “Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан”-г бүрдүүлэхийг хуульчилсан байна[6].

Монгол Улсын Их Хурлаас “Засгийн газрын тусгай сангийн тухай хууль”-ийг 2006 оны 06 дугаар сарын 29-ний батлан, 2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр шинэчлэн найруулсан.

*Хүснэгт 1.*

| № | 2006 оны хуулиар | | 2019 оны хуулиар | |
|---|---|---|---|---|
| | **Эрүүгийн хуулийн зүйл, заалт** | **Эрүүгийн хуулийн зүйл заалтын гарчиг** | **Эрүүгийн хуулийн зүйл, заалт** | **Эрүүгийн хуулийн зүйл заалтын гарчиг** |
| 1 | 10.1 дүгээр зүйл | Хүнийг алах | 10.1 дүгээр зүйл | Хүнийг алах |
| 2 | 11.1 дүгээр зүйл | Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах | 11.1 дүгээр зүйл | Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах |
| 3 | 12.1 дүгээр зүйл | Хүчиндэх | 11.4 дүгээр зүйл | Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах |
| 4 | 13.3 дугаар зүйл | Хүн барьцаалах | 12.1 дүгээр зүйл | Хүчиндэх |
| 5 | 13.4 дүгээр зүйл | Хүнийг хууль бусаар хорих, хүчээр алга болгох | 12.3 дугаар зүйл | Бэлгийн мөлжлөг |
| 6 | 17.2 дугаар зүйл | Дээрэмдэх | 13.1 дүгээр зүйл | Хүн худалдаалах |
| 7 | 19.3 дугаар зүйл | Төрийн өндөр албан тушаалтны амь биед халдах | 13.2 дугаар зүйл | Хүн хулгайлах |
| 8 | 21.12 дугаар зүйл | Эрүү шүүлт тулгах | 13.3 дугаар зүйл | Хүн барьцаалах |
| 9 | 29.1 дүгээр зүйл | Түрэмгий дайныг төлөвлөх, бэлтгэх, өдөөх, дэгдээх | 13.4 дүгээр зүйл | Хүнийг хүчээр алга болгох |
| 10 | 29.8 дугаар зүйл | Террор үйлдэх | 15.3 дугаар зүйл | Хүний цус, эс, эд, |

[6]“Засгийн газрын нөөц сангийн тухай хууль” шинэчилсэн найруулга, 2019. // https://www.legalinfo.mn/law/details/14848?lawid=14848

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | эрхтнийг хууль бусаар авах |
| 11 | - | - | 15.5 дугаар зүйл | Хууль бусаар үр хөндөх |
| 12 | - | - | 16.1 дүгээр зүйл | Хүүхдийг гэмт хэрэг үйлдэхэд татан оруулах |
| 13 | - | - | 16.3 дугаар зүйл | Хүүхдийг хаях, төөрүүлэх, тэнүүчлэлд хүргэх |
| 14 | - | - | 16.6 дугаар зүйл | Хүүхэд худалдах |
| 15 | - | - | 16.7 дугаар зүйл | Хүүхэдтэй хэрцгий харьцах |
| 16 | - | - | 16.11 дүгээр зүйл | Хүүхдийг асран хамгаалах үүргээ үл биелүүлэх |
| 17 | - | - | 17.2 дугаар зүйл | Дээрэмдэх |
| 18 | - | - | 19.3 дугаар зүйл | Төрийн өндөр албан тушаалтны амь биед халдах |
| 19 | - | - | 21.12 дугаар зүйл | Эрүү шүүлт тулгах |
| 20 | - | - | 29.1 дүгээр зүйл | Түрэмгий дайныг төлөвлөх, бэлтгэх, өдөөх, дэгдээх |
| 21 | - | - | 29.8 дугаар зүйл | Террорист үйлдэл хийх |

Гэхдээ уг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т “Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангийн хөрөнгийг Эрүүгийн хуулийн 10.1 дүгээр зүйл /Хүнийг алах/, 11.1 дүгээр зүйл /Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах/, 11.4 дүгээр зүйл /Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах/, 12.1 дүгээр зүйл /Хүчиндэх/, 12.3 дугаар зүйл /Бэлгийн мөлжлөг/, 13.1 дүгээр зүйл /Хүн худалдаалах/, 13.2 дугаар зүйл /Хүн хулгайлах/, 13.3 дугаар зүйл /Хүн барьцаалах/, 13.4 дүгээр зүйл /Хүнийг хүчээр алга болгох/, 15.3 дугаар зүйл /Хүний цус, эс, эд, эрхтнийг хууль бусаар авах/, 15.5 дугаар зүйл /Хууль бусаар үр хөндөх/, 16.1 дүгээр зүйл /Хүүхдийг гэмт хэрэг үйлдэхэд татан оруулах/, 16.3 дугаар зүйл /Хүүхдийг хаях, төөрүүлэх, тэнүүчлэлд хүргэх/, 16.6 дугаар зүйл /Хүүхэд худалдах/, 16.7 дугаар зүйл /Хүүхэдтэй хэрцгий харьцах/, 16.11 дүгээр зүйл /Хүүхдийг асран хамгаалах үүргээ үл биелүүлэх/, 17.2 дугаар зүйл /Дээрэмдэх/, 19.3 дугаар зүйл /Төрийн өндөр албан тушаалтны амь биед халдах/, 21.12 дугаар зүйл /Эрүү шүүлт тулгах/, 29.1 дүгээр зүйл /Түрэмгий дайныг төлөвлөх, бэлтгэх, өдөөх, дэгдээх/, 29.8 дугаар зүйл /Террорист үйлдэл хийх/-д заасан гэмт хэргийн улмаас амь насаа алдсан этгээдийн гэр бүлийн гишүүн, түүнчлэн хүнд гэмтэл учирсан хохирогчийн шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрт заасан дараах хохиролд нөхөн төлбөр олгоход зарцуулна” гэж ялгамжтай байхаар хуульчилжээ.

Дээрх хуулийн заалтуудыг судалж үзвэл хүний амь нас, эрүүл мэндэд хүч хэрэглэж үйлдсэн гэмт хэргийн хохирогчдод нөхөн төлбөр олгож байхаар хуульчилсан байна гэж үзэж байна.

Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж заасан гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг төрөөс нөхөн барагдуулах гол үзэл баримтлал болохыг дээр дурдсан.

Үүнд гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөөнд шууд учирсан хохирлыг хамааруулан ойлгох шаардлагатай.

Иймд гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөөнд учирч буй хохирлын хэмжээг тодорхойлсноор дээрх чиг үүргээ төр хэрхэн хангаж байгаад дүгнэлт хийхэд нөлөөлнө гэж үзэж байна.

Монгол Улсад үйлдэгдсэн гэмт хэргийн тоо, шүүхээс шийтгүүлсэн гэмт хэргийн тоон мэдээг 2017, 2018, 2019 оны байдлаар авч үзсэн болно.

2017 онд Улсын хэмжээнд нийт 32259 гэмт хэрэг бүртгэгдсэн ба 2018 онд 36220 гэмт хэрэг, 2019 онд 31524 гэмт хэрэг тус тус бүртгэгдсэн байна[7].

Үүнээс 2017 онд эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс нийт 10412 хэргийг, 2018 онд 14207 хэргийг, 2019 оны 3 дугаар улирлын байдлаар 11577 хэргийг тус тус хүлээн авч шийдвэрлэсэн байна[8].

*Зураг 1. Улсын хэмжээнд тухайн жилд бүртгэгдсэн болон шүүхээр шийтгүүлсэн гэмт хэргийн дүн.*




Мөн онуудад бүртгэгдсэн болон шүүхээр таслан шийдвэрлэгдсэн хэргийн тоонд хамаарах тухайн онд улсад болон хувийн өмч буюу иргэнд учирсан хохирлыг хэмжээг мөнгөн дүгнээр илэрхийлснийг харьцуулан үзэх шаардлагатай.

[7]Улсын хэмжээнд 2017, 2018, 2019 онд бүртгэгдсэн гэмт хэргийн мэдээ. Цагаагийн ерөнхий газрын цахим хуудас. // https://www.police.gov.mn/tailan/

[8]Монгол Улсын шүүхийн 2017, 2018, 2019 оны 3 дугаар улирлын шүүн таслах ажиллагааны тайлан. Шүүхийн статистик. Шүүхийн ерөнхий зөвлөлийн цахим хуудас. // https://www.judcoincil.mn/statistic/

2017 оны байдлаар улсын хэмжээнд гэмт хэргийн улмаас 198.073.2 сая төгрөгийн хохирол учирсан бол 2018 онд гэмт хэргийн улмаас 193.315 сая төгрөг[9], 2019 онд 162.346.6 төгрөгийн хохирол учирсан байна[10].

*Зураг 2. Гэмт хэргийн улмаас улсад учирсан хохирлын дүн /хэмжих нэгж сая.төг/*




Сүүлийн 3 жилийн байдлаар гэмт хэргийн хохирол буурч буй нь эерэг хэдий ч төр чиг үүргийнхээ хүрээнд хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөөнд учирсан хохирлыг барагдуулах үүрэг тооны өсөлт, бууралтаас үл хамаарах зайлшгүй үүрэг мөн.

Гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөөнд 2017 онд 186.593.5 сая төгрөг, 2018 онд 169.965 сая төгрөг, 2019 онд 155.067.7 сая төгрөгийн хохирол учирсан тухай статистик мэдээ бий[11].

Эдгээр нь улсын хэмжээнд учирсан хохирлын дийлэнх хувийг эзэлж байгаа ба гэмт хэргийн улмаас иргэд олон зуун тэрбум төгрөгийн хохирол хүлээж байгаад төр анхаарлаа хандуулах шаардлага зүй ёсоор тулгарсныг харуулж байгаа хэрэг.

*Зураг 3. Улсын хэмжээнд учирсан хохирол, иргэнд учирсан хохирлын дүн /хэмжих нэгж сая.төг/*




| | 2017 | 2018 | 2019 |
|---|---|---|---|
| Улсад | 198073,2 | 193315 | 162346,6 |
| Иргэнд | 186593,5 | 169965 | 155067,7 |

[9]2017, 2018 оны статистик. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан. 1212.mn

[10]Улсын хэмжээнд 2019 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээ. Статистик мэдээ. Цагдаагийн ерөнхий газрын цахим хуудас. // https://www.police.gov.mn/tailan/

[11]2017, 2018, 2019 оны статистик. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан. 1212.mn

### 1.1. Асуудлын мөн чанар, цар хүрээг тодорхойлсон байдал:

1. Гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөөнд учирсан аливаа хохирлыг нөхөн төлөх, арилгах, сэргээн эдлүүлэх нь төрийн чиг үүрэг тул энэ төрлийн эрх зүйн зохицуулалт, орчныг боловсронгуй болгох;

2. Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль, эрх зүйн актуудын зохицуулалтын цар хүрээг тодорхойлж дүгнэх, шинэ эрх зүйн зохицуулалтад тусгах санал зөвлөмжийг боловсруулах;

3. Хуулийн хүрээнд илүү тодорхой байдлаар зохицуулах, иргэдийн эрхийг хангаж, хамгаалах хүчин чадал бүхий эрх зүйн зохицуулалтыг бий болгоход шаардлагатай судалгааг хийх;

4. Албан тушаалтнууд болон иргэдийн эрх зүйн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх;

Энэ хүрээнд Олон улсын болон үндэсний эрх зүйн хэм хэмжээ, Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Үндэсний статистикийн хороо, Шүүхийн ерөнхий зөвлөл, Цагдаагийн ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын холбогдох тайлан мэдээ, судалгаа, зөвлөмж зэргийг судалж үзсэн болно.

### 1.2. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэдийг тодорхойлох:

Гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө нь зөрчигдөж байгаа нийгмийн бүлэг, иргэдийг хамааруулан авч үзлээ.

Эрүүгийн хуульд заасан нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдлийн улмаас гэмт хэргийн хохирогч болсон иргэдийг хамааруулсан болно.

Гэмт хэргийн улмаас 2017 онд 37117, 2018 онд 33566, 2019 оны байдлаар 30782 иргэн тус тус хохирсон байна[12].

*Зураг 4. Гэмт хэргийн улмаас нийт хохирсон иргэний тоо*




[12]Улсын хэмжээнд 2017, 2018, 2019 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээ. Цагдаагийн ерөнхий газрын цахим хуудас. // https://www.police.gov.mn/tailan/

Энэ нь дунджаар Монгол Улсын хүн амын 1-1.2 хувь нь гэмт хэргийн хохирогч болсон төдийгүй хохирсон нэг хүнд гэмт хэргийн улмаас дунджаар 5.259.666 төгрөгийн материаллаг хохирол учирсан болохыг харуулж байна.

### 1.3. Асуудлыг үүсгэж буй шалтгаан нөхцөл:

Гэмт хэргийн улмаас учирч буй хохирол, түүнийг арилгах, нөхөн сэргээх асуудал нь энэ судалгааны гол үндэс суурь болж байна.

Тиймээс гэмт хэргийн улмаас бий болсон хохирлыгхэрхэн барагдуулж байгааг тодорхойлох нь зүйтэй.

2017 оны байдлаар гэмт хэргийн улмаас учирсан хохирлоос 74.508.2 сая төгрөг, 2018 онд 32.444 сая төгрөг, 2019 онд 42.759.6 сая төгрөгийг тус тус нөхөн төлсөн байна[13].

Дээрх нөхөн төлөгдсөн байдал нь гэмт хэрэг үйлдсэн этгээдээс **хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхийн шатанд** төлүүлсэн дүн болохыг анхаарах хэрэгтэй.

Үүнээс үлдсэн гэмт хэргийн хохирлын хэмжээ нь төрөөс гэмт хэргийн хохирлыг нөхөн төлөх хэрэгцээг тодорхойлж байна.

*Зураг 5. Нийт учирсан хохирлын дүн болон нөхөн төлөгдсөн хохирлын дүн /хэмжих нэгж сая.төг/*




[13]Улсын хэмжээнд 2017, 2018, 2019 онд бүртгэгдсэн гэмт хэргийн мэдээ. Цагдаагийн ерөнхий газрын цахим хуудас6// https://www.police.gov.mn/tailan/

*Зураг 6. Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд барагдуулсан хувь*




Энэхүү үзүүлэлтээс харахад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гэмт этгээд бусдад учруулсан хохирлоо барагдуулах ажиллагаа 2017 онд 37.6 хувь, 2018 онд 16.8 хувь, 2019 онд 27 хувь байгаа ньхангалтгүй гэж дүгнэж болохоор байна.

**Шигтгээ 1.**

Гэмт хэргийн улмаас хохирсон 400 хохирогчоос анкетын аргаар авсан “Та гэмт хэргийн улмаас учирсан хохирлоо бүрэн авч чадсан уу?” гэсэн асуулгад судалгаанд оролцогчдын96 буюу 24 хувь нь “Тийм”, 304 оролцогч буюу 76 хувь нь “Үгүй” гэж тус тус хариулжээ.

Харин Цагдаагийн байгууллагын 100 мөрдөгчөөс мөн аргаар авсан судалгааны “Хохирогч нар гэмт хэргийн улмаас учирсан хохирлоо бүрэн авч чадсан уу?” гэсэн асуулгад нийт судалгаанд оролцогчдын 20 буюу 20 хувь нь “Тийм”, 80 оролцогч буюу 80 хувь нь “Үгүй” гэж тус тус хариулжээ.

Үүнээс дүгнэж үзвэл гэмт хэргийн улмаас хохирсон иргэд хохирлоо бүрэн гүйцэд авч чадахгүй байгаа нь төрөөс хүний эрхийг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг хангах заалт хэрэгжихгүй, хүний зөрчигдсөн хууль ёсны эрх, ашиг сонирхол нөхөн сэргээгдэж чадахгүй байгааг нотолж байна.

**Гэмт хэргийн хохирлыг төрөөс нөхөн төлж байгаа үйл ажиллагааны талаар:**

Манай улсад гэмт хэргийн хохирогчид төрөөс нөхөн төлбөр олгох зохицуулалт бий хэдий ч түүний үйлчлэл, нөөц боломж нь хомс байдаг.

Эрх зүйн зохицуулалтын хүрээнд Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд заасанаар “Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан” дараах эх үүсвэрээс бүрдүүлэхээр заасан байна. Үүнд:

1. Улсын төсвийн хөрөнгө;

2. Хандив, тусламж;

3. Шүүхээс ногдуулсан торгох ялыг биелүүлж, төсөвт тушаасан мөнгөн хөрөнгийн 60 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгө;

4. Шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр энэ хуулийн 10.3-т заасан гэмт хэрэгт гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон этгээдээс хохирол барагдуулсан төлбөрөөс бүрдэж байна.

Хууль хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 132 дугаар тогтоолоор “Зарим төрлийн гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох журам[14]”-ыг батлан гаргаж, 2018 оны 143 дугаар “Журамд өөрчлөлт оруулах тухай тогтоол[15]”-оор өөрчлөн найруулсан.

Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох санд 2019 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар 6.5 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгө төвлөрсөн бөгөөд Засгийн газрын 132 дугаар тогтоол батлан гарсанаас хойш буюу 2012-2019 оны хооронд 18 удаагийн тушаалаар нийт 305 хохирогчид 1.285.274.685 төгрөгийн нөхөн олговорыг “Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан”-гаас олгосон[16] байна.

*Хүснэгт 2.*

| № | ХЗДХСайдын тушаал | | Сангаас олгосон | | Дуусгавар болсон г/х | Санд төвлөрүүлсэн | Санд буцаан төвлөрүүлэх үлдэгдэл |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Огноо | Дугаар | Төлбөр авагчийн тоо | Хохирлын мөнгөн дүн | | | |
| 1 | 2012.11.02 | А/59 | 1 | 2,882,500 | - | 902,336 | 1,980,164 |
| 2 | 2013.05.03 | А/96 | 7 | 18,748,370 | 3 | 6,389,623 | 12,358,747 |
| 3 | 2013.09.04 | А/188 | 8 | 29,852,444 | 6 | 24,050,994 | 5,801,450 |
| 4 | 2013.12.09 | А/253 | 9 | 19,708,903 | 3 | 5,523,012 | 14,185,891 |
| 5 | 2014.03.13 | А/18 | 14 | 49,195,813 | 9 | 31,462,805 | 17,733,008 |
| 6 | 2014.12.23 | А/240 | 47 | 196,005,476 | 17 | 55,505,602 | 140,499,874 |
| 7 | 2015.03.24 | А/67 | 14 | 45,984,810 | 9 | 26,202,281 | 19,782,529 |
| 8 | 2015.07.03 | А/146 | 21 | 68,220,655 | 11 | 28,588,849 | 39,631,806 |
| 9 | 2015.11.24 | А/264 | 17 | 62,341,018 | 3 | 17,855,300 | 44,485,718 |
| 10 | 2016.04.08 | А/103 | 16 | 51,275,822 | 6 | 17,974,975 | 33,300,847 |
| 11 | 2016.08.23 | А/23 | 23 | 103,112,966 | 3 | 12,027,068 | 91,085,898 |
| 12 | 2016.12.12 | А/113 | 21 | 80,350,028 | 9 | 29,875,548 | 50,4744,480 |
| 13 | 2017.04.18 | А/91 | 18 | 76,491,984 | 4 | 16,557,780 | 59,934,204 |
| 14 | 2017.11.30 | А/281 | 21 | 96,583,889 | 4 | 21,391,859 | 75,192,030 |
| 15 | 2018.04.27 | А/81 | 16 | 87,510,740 | 1 | 11,069,142 | 76,441,598 |
| 16 | 2018.05.25 | А/102 | 3 | 19,314,620 | - | - | 19,314,620 |
| 17 | 2018.10.04 | А/189 | 12 | 53,789,565 | 2 | 5,780,849 | 48,008,716 |
| 18 | 2019.09.06 | А/173 | 18 | 97,222,571 | - | 2,991,374 | 94,231,197 |
| 19 | 2019.12.09 | А/228 | 19 | 126682511 | | | |
| **Нийт дүн** | | | **305** | **1.285.274.685** | **90** | **314,149,397** | **1.298.712.777** |

[14]Зарим төрлийн гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох журам// https://www.legalinfo.mn/annex/details/2868?lawid=7514
[15]Журамд өөрчлөлт оруулах тухай тогтоол // https://www.legalinfo.mn/law/details/13404
[16]ШШГЕГ-ын 12 дугаар сарын тайлан, мэдээ

Тус сангаас сүүлийн 3 жилийн байдлаар нийт 107 төлбөр авагчид 557.5 сая төгрөгийн нөхөн олговор олгосон байна. Энэ нь дундажаар нэг төлбөр авагч 5.210.280 төгрөгийн нөхөн төлбөр авсан үзүүлэлт юм.

Дээрх нөхөн олговрийг гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээтэй харьцуулж үзвэл тун хангалтгүй болох нь илэрхий юм.

*Зураг 7. Нийт учирсан хохирлын дүн болон нөхөн төлөгдсөн хохирлын дүн /хэмжих нэгж сая.төг/*




Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар Засгийн газрын тусгай сангаас гэмт хэргийн улмаас хохирсон зарим иргэдэд нөхөн төлбөр олгож байгаа хэдий ч нийт гэмт хэргийн улмаас учирсан хохиролтойхарьцуулахадтүүний нэг хувьд ч хүрэхгүй үзүүлэлт харагдаж байна.

**Шигтээ 2.**

Судалгаанд хамрагдсан Цагдаагийн байгууллагын 100 мөрдөгчөөс анкетын аргаар авсан “Та гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан байдаг гэдгийг мэдэх үү?” асуулгад нийт оролцогчдын 70 буюу 70 хувь нь “Мэдэхгүй”, 30 буюу 30 хувь нь “Мэднэ” гэж хариулсан бол гэмт хэргийн улмаас хохирсон 400 иргэнээс мөн аргаар авсан дээрх асуулгад нийт ороцсон иргэдийн 344 буюу 86 хувь нь “Мэдэхгүй”, 56 буюу 14 хувь нь “Мэднэ” гэж тус тус хариулсан.

Гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөөнд учирсан хохирлыг барагдуулах ажиллагаанд албан тушаалтан болон иргэдийн хохирлоо хэрхэн нөхөн төлүүлэх талаар эрх зүйн мэдлэг дутмаг байгааг харуулж байна.

Нөгөө талаас Засгийн газрын тусгай сангаас гэмт хэргийн улмаас хохирсон төлбөр авагчид нөхөн төлбөр олгохдоо зөвхөн хөдөлмөрийн чадваргүй гэмт этгээд, ялтан, хоригдлын үйлдсэн гэмт хэргийн улмаас бусдад учруулсан хохирлыг гаргуулж байгаа нь гэмт хэргийн хохирлыг төрөөс нөхөн барагдуулах тогтолцоо хангалттай бүрдээгүй болохыг тодорхойлж байна.

**Санд буцаан төвлөрүүлэх ажиллагааны талаар:**

"Зарим төрлийн гэмт хэргийн хохирогчид төрөөс нөхөн төлбөр олгох журам"-ын 7.1-д "Сангаас хохирогчид олгосон нөхөн төлбөрийг шүүхийн шийтгэх тогтоолоор гэм буруутай болох нь тогтоогдсон этгээдээр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль тогтоомжид заасны дагуу санд буцаан төвлөрүүлэхээр заасан.

Нийт 294 төлбөр төлөгч хоригдолд холбогдох 1.158.592.174 төгрөгийг эргэн төвлөрүүлэхээс шийдвэр гүйцэтгэх ажиллагаагаар 314.149.397 төгрөгийг зохих санд буцаан төвлөрүүлж, үүнээс 90 төлбөр төлөгчид холбогдох гүйцэтгэх баримт бичгийг дуусгавар болгожээ. Төлбөрийн үлдэгдэлтэй 204 төлбөр төлөгчийн 165 төлбөр төлөгч хорих ял эдэлж байна. Эргэн төвлөрүүлэлтийн биелэлт 27.1 хувьтай байна.

Улсын хэмжээнд эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэртэй иргэнд олгох шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны биелэлт нь хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөөнд учирсан хохирлын нөхөн төлөлтийг улсын хэмжээнд тодорхойлох гол үзүүлэлт юм.

*Хүснэгт 3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас 2017-2019 онд гүйцэтгэсэн эрүүгийн хэргийн шийдвэртэй хохирол барагдуулах ажиллагааны гүйцэтгэлийн дүн мэдээ*

*/мөнгөн дүнг хэмжих нэгж сая.төг/*

| № | Үзүүлэлт | Нийт | Гүйцэтгэсэн | Үлдэгдэл | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|
| **2017** | | | | | |
| **1** | Гүйцэтгэх хуудсын тоо | 5353 | 2324 | 3029 | 43.3% |
| **2** | Мөнгөн дүн | **43,279.2** | **3,805.6** | **39,472.5** | **8.8%** |
| **2018** | | | | | |
| **1** | Гүйцэтгэх хуудсын тоо | 5828 | 3569 | 2259 | 61.2% |
| **2** | Мөнгөн дүн | **48,853.2** | **9,473.5** | **39,379.6** | **19.4%** |
| **2019** | | | | | |
| **1** | Гүйцэтгэх хуудсын тоо | 5948 | 3354 | 2594 | 56.4% |
| **2** | Мөнгөн дүн | **71,812.8** | **7,745.1** | **64,067.7** | **10.8%** |

Дээрх дүн мэдээнээс үзэхэд гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг барагдуулах ажиллагаа гүйцэтгэх хуудасны биелэлт өндөр боловч, мөнгөн дүнгийн биелэлт бага байгаа нь гэмт хэргийн хохирлыг төрөөс нөхөн төлөх, иргэнийхээ зөрчигдсөн эрхийг сэргээх асуудалд анхаарах шаардлага бий болсныг нотолж байна.

Гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөөнд учирсан хохирлыг хэрхэн төлөгдөж байгааг тодорхойлох үүднээс гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн этгээдийн тоо, боловсрол, хөдөлмөр эрхлэлтийн байдалд дүн шилжилгээ хийлээ.

2017 онд ял шийтгүүлсэн 9019 хүн, 2018 онд 12366 хүн, 2019 оны 3 дугаар улирлын байдлаар 10149 хүн байна. Үүнээс 2017, 2018 онд ял шийтгүүлэгчдийн боловсрол, хөдөлмөр эрхлэлтийг авч үзвэл:

- Боловсролын байдлаар нь авч үзвэл 2017 онд нийт ял шийтгүүлэгчдийн 16 хувь нь дээд, 6 хувь нь суурь, 10 хувь нь бага, 21 хувь нь боловсролгүй, 42 хувь нь бүрэн дунд, 5 хувь нь тусгай дунд болон бусад боловсролтой хүмүүс байна.

2018 онд 17.7 хувь нь дээд, 17.7 хувь нь суурь, 8.8 хувь нь бага, 5.9 хувь нь боловсролгүй, 44.3 хувь нь бүрэн дунд, 5.7 хувь нь тусгай дунд болон бусад боловсролтой хүмүүс байна.

- 2017 онд хөдөлмөр эрхлэлтийн хувьд төрийн албанд 3.3 хувь, 23.9 хувийн хэвшлийн байгууллагад 2.5 хувь нь сурагч, 3.1 хувь нь оюутан, 4.9 хувь нь оюутан, 61.9 хувь нь эрхэлсэн тодорхой ажилгүй хүмүүс эзэлж байна.

2018 онд ял шийтгүүлэгчдийн 5.6 хувь нь төрийн албанд, 36.8 хувь нь хувийн хэвшлийн байгууллагад, 1.9 хувь нь сурагч, 9.5 хувь нь малчин, 68.9 хувь нь эрхэлсэн тодорхой ажилгүй хүмүүс байна.

*Зураг 8. Ял шийтгүүлсэн хүмүүсийн боловсролын байдал*




Дээрх судалгаанаас харахад 2017, 2018 онд шүүхээр ял шийтгүүлсэн хүмүүсийн олонхи нь бүрэн дунд боловсролтой, мөн боловсролгүй иргэд байна.

*Зураг 9. Ял шийтгүүлсэн хүмүүсийн хөдөлмөр эрхлэлтийн байдал*



Дээрх судалгаанаас дүгнэжүзвэл гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн хүмүүсийн 60-аас илүү хувь нь эрхэлсэн тодорхой ажилгүй байгаа нь өөрийн үйлдсэн гэмт хэргийн улмаас иргэнд учруулсан хохирлоо тухай бүр нөхөн төлөх чадвар төдийлөн хангалттай бус болохыг илэрхийлж байна.

**Шигтгээ 3.**

Засгийн газрын тусгайн сангийн тухай хуульд тусгасан 21 төрлийн гэмт хэргээс бусад хүний амь нас, эрүүл мэндийн эсрэг үйлдэгдсэн хэргийн хохирогчдын хохирлыг хэрхэх вэ гэдэг асуудал тулгараад байна.

Нэгэн жишээ дурдвал: Хүний амь нас хохироогүй атлаа зөвхөн мөнгөн хөрөнгөө нэр бүхий 26 хадгаламж зээлийн хоршоонд хадгалуулсан хадгаламж эзэмшигч нарыг хохирлыг 2007 онд Улсын Их Хурлаас“Хохирлыг эргэн төлөгдөх нөхцөлөөр барагдуулах тухай” хууль баталж, 33.0 тэрбум төгрөгийг хадгаламж эзэмшигч нарт олгосон байдаг. Түүнчлэн 2014 онд УИХурлаас уг хуульд дахин нэмэлт, өөрчлөлт оруулж, улмаар хохирлыг мөнгийг дахин улсаас олгохоор хуульчилсан байдаг.

Өөрөөр хэлбэл Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар дээрх гэмт хэргийн хохирогчдод төрөөс нөхөн төлүүлэхээр хуульчилсан хэдий ч бусад төрлийн гэмт хэргийн хохирогчдын амь нас, эрүүл мэндэд учирсан хохирлыг нөхөн төлүүлэхгүйгээр орхигдуулсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1-д  заасан “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж заасантай зөрчилдөж байгааг харуулж байна.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд тусгасан 21 төрлийн гэмт хэрэгт мөн сангаас нөхөн төлбөр олгох талаар заасан бөгөөд тухайн төрлийн гэмт хэргийн гаралтыг бусад нийтлэг үйлдэгддэг 6 төрлийн гэмт хэргийн гаралттай харьцуулан авч үзлээ.

2019 оны байдлаар Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд тусгасан гэмт хэргүүдээс нийтлэг үйлдэгдсэн тоог авч үзье. Үүнд:

- “Хүнийг алах” гэмт хэрэг197,
- “Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах” гэмт хэрэг 238,
- “Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах” гэмт хэрэг 319,
- “Хүчиндэх” гэмт хэрэг 481,
- “Бэлгийн мөлжлөг” гэмт хэрэг 6,
- “Хүн худалдаалах” гэмт хэрэг 14,
- “Хүн хулгайлах” гэмт хэрэг 4,
- “Хүнийг хүчээр алга болгох” гэмт хэрэг 3,
- Хүүхдийн эсрэг гэмт хэрэг 31,
- “Дээрэмдэх” гэмт хэрэг 868 удаабуюу нийт 2161 гэмт хэрэг байна.

*Зураг 10. ЗГ-ын тусгай сангийн тухай хуульд тусгасан гэмт хэргийн 2019 онд үйлдэгдсэн байдал*




Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан 21 төрлийн гэмт хэрэг нь нийт 2161 буюу улсын хэмжээнд 2019 онд бүртгэгдсэн гэмт хэргийн 6.8 хувийг эзэлж байгаа нь гэмт хэргийн улмаас иргэнд учирсан хохирлыг төрөөс нөхөн барагдуулах өнөөгийн орчныг илэрхийлж байна.

Гэмт хэргийн улмаас хүний амь бие, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөөнд шууд хор уршиг, хохирол учруулдаг боловч Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд тусгаагүй 59 төрлийн гэмт хэрэг байна. Үүнээс нийтлэг үйлдэгпэж буй 6 төрлийн гэмт хэргийг тусгайлан авч үзлээ. Үүнд:

- “хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх” гэмт хэрэг 104,
- “хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах” гэмт хэрэг 7394,
- “гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх” гэмт хэрэг 207,
- “заналхийлэх” гэмт хэрэг 53,
- “хулгайлах” гэмт хэрэг 8968,
- “залилах” гэмт хэрэг 4688 удаа буюу нийт 21414 удаа гэмт бүртгэгдсэн байна.

*Зураг 11. Эрүүгийн хуульд заасан 59 төрлийн гэмт хэргээс зонхилон үйлдэгдэж буй 6 гэмт хэргийн 2019 онд бүртгэгдсэн байдал*



Энэ нь 2019 онд улсын хэмжээнд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 68.2 хувийг эзэлж байна.

**Шигтгээ 4.**

Цагдаагийн байгууллагад гэмт хэргийн улмаас хохирсон 400 хохирогчоос анкетын аргаар авсан “Та ямар гэмт хэргийн хохирогч болж байсан бэ?” гэсэн асуултад давхардсан тоогоор 8 оролцогч буюу 2 хувь нь “Хүний эрүүл мэнд халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг”-ийн, 8 оролцогч буюу 2 хувь нь “Хүний бэлгийн эрх чөлөө,халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг”-ийн, 40 оролцогч буюу 10 хувь нь “Хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг”-ийн, 160 оролцогч буюу 40 хувь нь “Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг”-ийн, 184 оролцогч буюу 46 хувь нь “Хөдөлгөөний аюулгүй байдал,тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг”-ийн хохирогч тус тус болж байсан хэлж хариулжээ.

Харин Цагдаагийн байгууллагын 100 мөрдөгчөөс мөн аргаар авсан судалгааны “Таны ажил үүргээ хэрэгжүүлэх явцад ямар төрлийн гэмт хэргийн хохирогч дийлэнхи тохиолдолд хандаж байна вэ? /Гурваас доошгүйг дугуйлна уу/” гэсэн асуулгад давхардсан тоогоор нийт оролцогчдын 8 буюу 8 хувь нь “Хүний амьд явахын эсрэг гэмт хэрэг”-ийн, 44 оролцогч буюу 44 хувь нь “Хүний эрүүл мэнд халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг”-ийн, 26 оролцогч буюу 26 хувь нь “Хүний бэлгийн эрх чөлөөтэй байх эрхийн гэмт хэрэг”-ийн, 2 оролцогч буюу 2 хувь нь “Хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн гэмт хэрэг”-ийн, 10 оролцогч буюу 10 хувь нь “Хүний хувийн, улс төрийн эрх, чөлөөний эсрэг гэмт хэрэг”-ийн, 14 оролцогч буюу 14 хувь нь “Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг”-ийн, 16 оролцогч буюу 16 хувь нь “Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг”-ийн гэж тус тус хариулжээ.

Судалгаанаас харахад хүний “халдашгүй байдлын эсрэг”, “эрүүл мэндийн эсрэг”болон “өмчлөх эрхийн эсрэг” гэмт хэрэг зонхилон үйлдэгддэг болох нь харагдаж байна.

Иймд Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд заасан 21 төрлийн гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг төрөөс нөхөн барагдуулах эрх зүйн зохицуулалттай боловч дээрх хуульд тусгагдаагүйулсын хэмжээнд нийтлэг үйлдэгддэг 6 төрлийн гэмт хэргийн гаралтын түвшинтэй харьцуулахад 10 хувьтай тэнцэж байгаа нь гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөөнд учирсан хохирлыг төрөөс нөхөн төлөх хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох, шинэ эрх зүйн зохицуулалт бий шаардлагатай байгааг илтгэж байна.

## ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛТЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

Аргачлалын 4-т заасны дагуу асуудлыг шийдвэрлэх зорилгыг дараах байдлаар тодорхойлж байна.

Иргэдийн зөрчигдсөн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг түргэн хугацаанд сэргээн эдлүүлэх, учирсан гэм хорыг арилгах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, иргэдэд учирсан хохирлыг төрөөс нөхөн төлүүлэх хэрэгцээ, шаардлагыг тодорхойлоход оршино.

## ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЕРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

*Хүснэгт 4.*

| Хувилбар | | Зорилгодоо хүрэх байдал | Зардал, үр өгөөжийн харьцаа | Үр дүн |
|---|---|---|---|---|
| 1 | Тэг хувилбар | Өнөөгийн тулгамдаад байгаа бэрхшээл хэвээр үргэлжилсээр, хүндрэнэ. | Нэмэлт зардал гарахгүй ч, сөрөг үр дагавар улам бүр ч нэмэгдэнэ. | Үр дүн сөрөг |
| 2 | Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх | Өнөөгийн тулгамдаад байгаа бэрхшээл хэвээр үргэлжлэх бөгөөд хууль тогтоомж хоорондын давхардал, хийдэл, зөрчил арилахгүй | Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийтэй холбогдсон зардал тодорхой хэмжээнд гарна. Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаварыг бууруулж чадахгүй. | Тодорхой үр дүнд хүрэхгүй |
| 3 | Зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх | Хууль тогтоомж хоорондын давхардал, хийдэл зөрчлийг элдийн засгийн арга хэрэгслээр зохицуулах боломжгүй. | Зардал шаардагдана. Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаварыг бууруулж чадахгүй. | Тодорхой үр дүнд хүрэхгүй |
| 4 | Төрөөс санхүүгийн зохицуулалт хийх | Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг төрөөс нөхөн барагдуулах санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэснээр зарим үйл ажиллагааг дэмжих хэдий ч зорилгыг хангаж чадахгүй | Зардал шаардагдана. Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаварыг бууруулж чадахгүй. | Тодорхой үр дүнд хүрэхгүй |
| 5 | Захиргааны шийдвэр гаргах | Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг төрөөс нөхөн барагдуулах үйл ажиллагааг зохицуулсан дүрэм, журмыг баталж тодорхой асуудлуудыг шийдвэрлэж болох хэдий ч хууль хоорондын уялдаа холбоог хангахгүй. | Асуудлуудыг үүсгэж байгаа шалтгааныг арилгахад цогцоор нөлөөлж, сөрөг үр дагаварыг бүрэн бууруулж чадахгүй. | Тодорхой үр дүнд хүрэхгүй |
| 6 | Хууль тогтоомжийн төсөл боловсруулах | Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг төрөөс нөхөн барагдуулах үйл ажиллагаанд тулгамдаад байгаа бэрхшээл, асуудлыг шийдвэрлэх бөгөөд зорилгод хүрэх боломжтой. | Зардал гарах боловч энэ нь хувилбар нь асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг шийдвэрлэхэд чухал нөлөө үзүүлэх боломжтой. | Үр дүнтэй |

## ДӨРӨВ.ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

Аргачлалын 6-д заасны дагуу өмнөх үе шатанд сонгон авсан хуулийн төсөл боловсруулах хувилбарын үр нөлөөг аргачлалд заасны дагуу ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлтийг нэгтгэн гаргалаа.

Жич: Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг шалгуур асуултын дагуу тандсан байдлыг хүснэгт 1, 2, 3, 4-өөс үзнэ үү.

**4.1.Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө**

Төрөөс хүний эрхийг хамгаалах, бататгах чиг үүргээ хэрэгжүүлж, гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрх, ашиг сонирхлыг сэргээснээр Хүний эрхийн түгээмэл тунхаглал хийгээд Монгол Улсын Үндсэн хуулиар бэхжүүлсэн хүний эрх, эрх чөлөө хангагдаж, хүний нийтлэг хүсэл, эрх ашиг хамгаалагдана..

**4.2.Эдийн засагт үзүүлэх үр нөлөө**

Улсын төсөвт тодорхой хэмжээнд нөлөө үзүүлэх хэдий ч гэмт хэргийн улмаас хохирсон хохирлыг төрөөс нөхөн төлүүлснээр иргэдийн зөрчигдсөн эрх, ашиг сонирхол болон бусад баталгаа хангагдаж,чадавхдээшлэнэ.

**4.3.Нийгэмд үзүүлэх үр нөлөө**

Нийгэмд ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй. Харин эрх зүйн зохицуулалтыгболовсронгуй болгосноор иргэд гэмт хэргийн улмаас зөрчигдсөн хууль ёсны эрх, ашиг сонирхлоо хамгаалуулах, учирсан хохирлоо нөхөн төлүүлэх эрх зүйн баталгаа хангагдана.

**4.4.Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө**

Байгаль орчинд ямар нэгэн шууд болон шууд бус сөрөг нөлөө үзүүлэхгүй.

## ТАВ.ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ

Аргачлалын 7-д зааснаар хувилбарын эерэг болон сөрөг талуудыг

- Зорилгод хүрэх байдал;

- Зардал, үр өгөөжийн харьцаа;

- Хүний эрх, эдийн засагт, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө;

- Хууль тогтоомжтой нийцэж буй эсэх;

- Гарч болох сөрөг үр дагавар, түүнийг арилгах хувилбар байгаа эсэх гэсэншалгуураар дахин нягтлан үзэж дараахь дүгнэлтийг хийлээ.

Монгол Улсын Үндсэн хууль, Олон улсын гэрээ, дотоодын хууль тогтоомж, Монгол Улсад сүүлийн 3 жилийн хугацаанд үйлдэгдсэн гэмт хэргийн статистик, гэмт хэргийн улмаас иргэнд учирсан хохирол, эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэрийн биелэлт зэргийг харьцуулан дүгнэхэд хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох замаар шийдвэрлэх боломжтой юм.

## ЗУРГАА.ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ:

Гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх чиглэлийн хүрээнд өнөө үед эрх зүйн тогтолцооны хувьд дэлхий нийтэд тэргүүлэх туршлага бүхий дараах орнуудын эрх зүйн зохицуулалтыг судланавч үзлээ.

**Америкийн Нэгдсэн Улсын хувьд:**

Холбооны хэмжээнд 1984 батлагдсан Гэмт хэргийн хохирогчийн тухай хууль (Victims of Crime Act - VOCA) нь өнөөдрийг хүртэл хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа бөгөөд уг хуульд 1988, 1993-1997, 1999-2002 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

Уг хуулиар гэмт хэргийн хохирогчийн сан байгуулах, санг бүрдүүлэх, санхүүжүүлэх, хуваарилах, гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох зардал, нөхөн төлбөр олгох эрх зүйн үндэслэл, олгох журам, уг ажлыг зохион байгуулах зэрэг асуудлыг хуульчилсан байна.

Энэхүү хуульд зааснаар Холбооны хэмжээнд АНУ-ын Хууль зүйн яамны Гэмт хэргийн хохирогчийн алба нь тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжүүлэх, сангийн мөнгөн хөрөнгийг хуваарилах, хэрэгжүүлэх, хяналт тавих ажлыг хариуцан ажилладаг ажээ.

АНУ-ын 50 мужид гэмт хэргийн хохирогчийн тухай хуулийг батлан гаргасан бөгөөд муж бүр тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжүүлдэг байна. Гэмт хэргийн хохирогчийн тухай хуульд заасны дагуу гэмт хэргийн хохирогчийн сангаас мужуудын хөтөлбөрийг санхүүгийн эх үүсвэрээр хангаж байна. 1884 онд батлагдсан Гэмт хэргийн хохирогчийн тухай хуулийн үзэл баримтлалын хүрээнд АНУ-ын хэмжээнд гэмт хэргийн хохирогчийн тухай хуулийн дагуу муж бүр гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох хөтөлбөр хэрэгжүүлж байгаагийн хамт уг асуудалтай холбогдсон зүйлтэй нийтлэг дараах эрх зүйн зохицуулалт байна.

АНУ-ын муж бүрт гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох хөтөлбөр хэрэгжүүлж байгаа бөгөөд уг хөтөлбөрийн дагуу хүч хэрэглэсэн гэмт хэргийн улмаас хохирсон этгээдэд санхүүгийн тусламж үзүүлж байна. АНУ-ын Хууль зүйн яам нь Гэмт хэргийн хохирогчийн албаар дамжуулан дээрх хуулийн дагуу хөтөлбөрийн санхүүжилт болон техникийн туслалцааг муж бүрт үзүүлж байдаг байна.

**Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын хувьд:**

ХБНГУлс нь Хүч хэрэглэсэн гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох тухай хуулийг 1976 онд батлан гаргаж, хүчин төгөлдөр мөрдөж байгаа бөгөөд нөхөн төлбөр олгох хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Хөтөлбөрийн дагуу хүч хэрэглэсэн гэмт хэргийн улмаас хохирсон этгээдэд санхүүгийн нөхөн төлбөр олгодог байна.

Хүч хэрэглэсэн гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох тухай хуулиар нөхөн төлбөр авахад тавигдах хууль зүйн үндэслэл, гомдол гаргах, шийдвэрлэх журам, нөхөн төлбөр олгохгүй байх үндэслэл, нөхөн төлбөр олгох зардал, гэмт хэргийн хохирогчид үзүүлэх тусламж, санхүүжүүлэх зэрэг нийтлэг асуудлыг зохицуулсан байна.

**Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын хувьд:**

ИБУИНВУлсад гэмт хэргийн хохирлын нөхөн төлбөрийн тухай хуулийг (Criminal Injuries Compensation Act 1995) 1995 онд батлан гаргасан бөгөөд гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох хөтөлбөр хэрэгжүүлдэг байна. Уг хөтөлбөрийн дагуу хүч хэрэглэсэн гэмт хэргийн улмаас хохирсон этгээд санхүүгийн нөхөн төлбөр олгодог байна.

Тухайн хуульд заасны дагуу нөхөн төлбөр олгох хөтөлбөрийг төрийн бие даасан байгууллага хэрэгжүүлдэг, хөтөлбөрийн зорилго нь хүч хэрэглэсэн гэмт хэргийн улмаас хохирсон этгээдэд санхүүгийн нөхөн төлбөр олгоход оршино. Хөтөлбөрт зааснаар хохирогч нь эрүүл мэндийн талаасаа өвчтэй байх, гэмтлийн нөхцөлийг анагаах ухааны хувьд тодорхойлсон байх ёстой.

**Япон улсын хувьд**:

Япон улсын гэмт хэргийн хохирогчид төлбөр олгох тухай хууль нь 1980 онд батлагдсан бөгөөд харин одоо уг хуулийг Санхүүгийн болон бусад туслалцаа үзүүлэх тухай хууль гэж нэрлэх болсон байна. Япон улс нь гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох хөтөлбөртэй бөгөөд гэмт хэргийн улмаас хохирсон этгээд санхүүгийн нөхөн төлбөр олгодог.

Японд Үндэсний нийтийн хамгаалах газрын Гэмт хэргийн хохирогчийн алба гэх байгууллага гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох ажлыг эрхлэн явуулдаг байна. Мөн Үндэсний цагдаагийн байгууллага нь уг ажлыг хариуцан ажиллаж байна.

**Оросын Холбооны Улсын хувьд**:

ОХУ нь 2004 онд хохирогч, гэрч болон эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны бусад оролцогчдын төрийн хамгаалалтын тухай хуулийг батлан гаргаж, 2005 оны 1 дүгээр сараас эхлэн хүчин төгөлдөр мөрдөж байна. 2006 оноос эхлэн Засгийн газраас хөтөлбөр хэрэгжүүлж байна.

ОХУ нь Хөтөлбөрийн санхүүжилтийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр хөтөлбөр заасан байна.

Судалсан орнуудын хувьд “Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн барагдуулах” бие даасан хууль батлан мөрддөг. Мөн үүний зэрэгцээ Хохирлыг нөхөн барагдуулах хөтөлбөрийг хэрэгжүүлдэг ажээ. Эдгээр орнуудын хувьд “Хохирол нөхөн барагдуулах тухай” бие даасан хуультай боловч энэхүү хууль нь зөвхөн “Хүч хэрэглэсэн гэмт хэргийн улмаас хохирсон этгээд”-д үйлчилдэг онцлогтой байна.

## ДОЛОО. ЗӨВЛӨМЖ

Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт *“Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.”* гэсэн заалтыг нэг мөр ойлгож, хуулийг зөв хэрэглэх нь зүйтэй;

Эрх зүйн тогтолцооны хувьд хөгжингүй орнууд болох АНУ, ХБНГУ, ИБУИНВУ, ОХУ, Япон Улсын туршлагыг судалж, энэхүү харилцааг Монгол Улсын нөхцөл байдалд уялдуулан, хүний зөрчигдсөн эрхийг сэргээн, үргэлжлүүлэн эдлүүлэх зайлшгүй хэрэгцээ шаардлага тулгарч байгаа тул бие даасан хуулиар нэг мөр зохицуулах;

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг төрөөс нөхөн барагдуулах тогтолцоог бүрдүүлэхийн тулд бие даасан хуулийн төсөл боловсруулж, батлан гаргах хувилбарыг сонгох нь зүйтэй гэж үзэж байна.

Тус хуулиар дараахь асуудлыг нарийвчлан зохицуулах шаардлагатай байна. Үүнд:

-Хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөөнд хохирол учруулдаг гэмт хэргийн хохирогчдын хохирлыг төрөөс урьдчилан гаргуулах талаар хуулийн зохицуулалтыг нарийвчлан тусгах;

- Гэмт хэргийн хохирогчдын эдийн засаг, нийгмийн байдлаас үл шалтгаалан ялгаварлахгүйгээр хохирлыг төрөөс нөхөн олгох талаар зохицуулалтыг тусгах;

- Гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эдийн засаг, нийгмийн байдлаас үл шалтгаалан хохирогчдын хохирлыг төрөөс нөхөн барагдуулах талаар хуулийн зохиулалтыг нарийвчлан тусгах;

- Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг төрөөс нөхөн барагдуулах тусгай сангийн орлогыг хэрхэн бүрдүүлэх, сангаас гаргасан төлбөрийг хэрхэн гэмт этгээдээс буцаан авч нөхөх байршуулах талаар зохицуулалтыг зайлшгүй тусгах;

- Хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах хүрээнд холбогдох зохицуулалтыг Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүгийн хууль, Иргэний хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиудын зүйл, заалтуудтай нийцүүлэх зэрэг болно.

# АШИГЛАСАН МЭДЭЭЛЭЛ, СУДАЛГАА, ГАРЫН АВЛАГА, ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ЖАГСААЛТ

**Хууль тогтоомжийн жагсаалт:**

1. Монгол Улсын Үндсэн хууль// Төрийн мэдээлэл эмхэтгэл. 1992. № 1.

2. Эрүүгийн хууль // Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2016. № 7.

3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль // Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2017. № 23.

4. Иргэний хууль // Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2002. № 7.

5. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль // Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2002. № 8.

6. Засгийн газрын тусгай сангийн тухай хууль // Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2019. № 48.

7. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль // Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2017. № 24.

8. Хохирлыг эргэн төлөгдөх нөхцөлөөр барагдуулах тухай хууль// Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2007. № 32.

9. Зарим төрлийн гэмт хэрэгт төрөөс нөхөн төлбөр олгох журам. Монгол Улсын Засгийн газрын 2011 оны тогтоол №132.Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем // URL: https://www.legalinfo.mn/annex/details/2868?lawid=7514

10. Хохирлыг эргэн төлөгдөх нөхцөлөөр барагдуулах журам Монгол Улсын Засгийн газрын тогтоол2007.09.27.№242. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем // URL: https://www.legalinfo.mn/annex/details/2240?lawid=2632

**Ашигласан мэдээлэл, судалгаа, гарын авлага, илтгэл, өгүүлэл:**

1. Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном 2016, Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, УБ хот, 2017 он.

2. Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном 2017, Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, УБ хот, 2018 он.

3. Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном 2018, Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, УБ хот, 2019 он.

4. Магистрын ажлын товчоон, ХСИС, УБ хот, 2018 он.

Хавсралт 1

# ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ

*/Хүснэгт1/*

| Үзүүлэх үр нөлөө: | Холбогдох асуултууд | Хариулт | | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1. Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж буй эсэх | 1.1. Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх | | | |
| | 1.1.1. Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх | **Тийм** | Үгүй | Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг төрөөс нөхөн барагдуулахдаа хохирогчийг алагчлалгүйгээр нөхөн төлбөр олгох зохицуулалтыг хуульчилна. |
| | 1.1.2. Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх | Тийм | **Үгүй** | Тодорхой шалгуур тавьж, хязгаарлалт тогтоох боловч энэ нь ялгаварлан гадуурхсан зохицуулалт биш. |
| | 1.1.3. Энэ нь тодорхой бүлгийн эмзэг байдлыг дээрдүүлэхийн тулд авч буй түр арга хэмжээ мөн бол олон улсын болон үндэсний хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж буй эсэх | Тийм | **Үгүй** | Тодорхой нийгмийн бүлэг, хэсэгт чиглэсэн зохицуулалт биш бөгөөд олон улсын болон үндэсний хүний эрхийн хэм хэмжээнд нийцсэн. |
| | 1.2.Оролцоог хангах | | | |
| | 1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх,ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх | **Тийм** | Үгүй | Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг төрөөс нөхөн барагдуулах хэрэгцээ, шаардлагыг судлахдаамөрдөгч, прокурор, шийдвэр гүйцэтгэгч, хохирогчдын саналыг үндэслэж хуулийн төслийг боловсруулна. |
| | 1.2.2. Ялангуяа зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх | **Тийм** | Үгүй | Бүлгүүдийг тусгайлан тодорхойлж, тэдэнд үзүүлэх үр нөлөөг үзүүлнэ. |
| | 1.3. Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал хариуцлага | | | |
| | 1.3.1. Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх | **Тийм** | Үгүй | Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжоор тогтоосон хүний эрхийг хамгаалах, дэмжлэг үзүүлэх тогтолцоо бүрдэнэ. |
| | 1.3.2. Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын Олон улсын гэрээ, НҮБ-ын хүний эрхийн механизмаас тухайн асуудлаар өгсөн зөвлөмжид | **Тийм** | Үгүй | Шударга, тэгш эрх, үр өгөөжтэй байх, нөхцөл, боломжийг бүрдүүлэхэд чиглүүлсэн. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | нийцэж байгаа эсэх | | | |
| | 1.3.3. Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх | Тийм | **Үгүй** | Хууль зөрчсөн, гэм буруутай, нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэлд холбогдох хуульд зааснаар хариуцлага хүлээлгэнэ. |
| 2. Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх | 2.1. Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах бол энэ нь хууль ёсны зорилгод нийцсэн эсэх | Тийм | **Үгүй** | Шударга ёсонд нийцсэн шаардлагын үндсэн дээр хүний эрхийг хөхиүлэн дэмжинэ. |
| 3. Эрх агуулагч | 3.1. Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх | **Тийм** | Үгүй | • Гэмт хэргийн улмаас хохирсон иргэн |
| | 3.2. Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодохойлсон эсэх | Тийм | **Үгүй** | Гэмт хэргийн улмаас хохирсон хүнийг ялгаж тодорхойлох шаардлагагүй |
| | 3.3. Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх | Тийм | **Үгүй** | Гэмт хэргийн улмаас хохирсон хүнийг ялгаж тодорхойлох шаардлагагүй бөгөөд тэдний хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хангана. |
| 4. Үүрэг хүлээгч | 4.1. Үүрэг хүлээгчийг тодорхойлсон эсэх | **Тийм** | Үгүй | Төр гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг барагдуулах, гэмт буруутай этгээдээр нөхөн төлүүлэх үүрэг хүлээнэ. |
| 5. Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх | 5.1. Жендерийн үзэл баримтлалыг тусгасан эсэх | **Тийм** | Үгүй | Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэхэд жендерийн тэгш байдлыг хангана. |
| | 5.2. Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлсэн эсэх | **Тийм** | Үгүй | Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэхэд хүйсээр ялгаварлахгүй олгоно. |

## ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

*/ Хүснэгт 2/*

| Үзүүлэх үр нөлөө: | Холбогдох асуудлууд | Хариулт | | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдах чадвар | 1.1. Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлсэн эсэх | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. |
| | 1.2. Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх /эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан/ | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. |
| | 1.3. Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөлийг Монгол Улсын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. |
| 2. Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал | 2.1. Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. |
| | 2.2. Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. |
| | 2.3. Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. |
| | 2.4. Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. |
| 3. Аж ахуйн нэгжийн үйлдвэр-лэлийн болон захиргааны зардал | 3.1. Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлсэнээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. |
| | 3.2. Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. |
| | 3.3. Зах зээлээс тодорхой бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. |
| | 3.4. Бараа бүтээгдэхүүний борлуулалтанд ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. |
| | 3.5. Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 4. Мэдээллэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал | 4.1. Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал, / Тухайлбал, мэдээллэх, тайлан гаргах г.м/ бий болгох эсэх | **Тийм** | Үгүй | Нэмэлт зардал үүсэхгүй. |
| 5. Өмчлөх эрх | 5.1. Өмчлөх эрхийг /үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг/ хөндсөн зохицуулалт бий болох эсэх | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. |
| | 5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. |
| | 5.3. Оюуны өмчийн/ патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг/ эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. |
| 6. Инноваци болон судалгаа шинжилгээ | 6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. |
| | 6.2. Үйлдвэрлэлийн шинэ технологи технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. |
| 7. Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв | 7.1. Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн эерэг, сөрөг нөлөө байхгүй. |
| | 7.2. Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх | **Тийм** | Үгүй | Эерэг нөлөө үзүүлнэ. |
| | 7.3. Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх | **Тийм** | Үгүй | Эерэг нөлөө үзүүлнэ. |
| | 7.4. Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд шууд буюу урт хугацааны туршид/ нөлөө үзүүлэх эсэх | **Тийм** | Үгүй | Эерэг нөлөө үзүүлнэ. |
| 8. Тодорхой бүс нутаг, салбарууд | 8.1. Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх | Тийм | **Үгүй** | Ямар нэг сөрөг нөлөө байхгүй. |
| | 8.2. Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх | Тийм | **Үгүй** | Ямар нэг сөрөг нөлөө байхгүй. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | 8.3 Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх | Тийм | **Үгүй** | Ямар нэг сөрөг нөлөө байхгүй. |
| 9. Төрийн захиргааны байгууллага | 9.1. Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх | Тийм | **Үгүй** | Улсын төсөвт ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй. |
| | 9.2. Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй. |
| | 9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх | **Тийм** | Үгүй | Хуулийн дагуу зарим чиг үүрэг нэмэгдэх боловч дотоод зохион байгуулалтын хүрээнд шийдвэрдлэх боломжтой. |
| 10. Макро эдийн засгийн хүрээнд | 10.1. Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх | **Тийм** | Үгүй | Эерэг нөлөө үзүүлнэ. |
| | 10.2. Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх | Тийм | **Үгүй** | Ямар нэг сөрөг нөлөө байхгүй. |
| 11. Олон улсын харилцаа | 11.1.Монгол улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх | **Тийм** | Үгүй | Ямар нэгэн байдлаар зөрчилдөхгүй. |

## НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

*/ Хүснэгт 3/*

| Үзүүлэх үр нөлөө | Холбогдох асуулт | Хариулт | | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл | 1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх | Тийм | **Үгүй** | Шинэ эрх зүйн зохицуулалтаас хамаарч төрийн байгууллагын бүтэц, чиг үүрэгт өөрчлөлт орсон тохиолдолд шинээр ажлын байр бий болох боломжтой |
| | 1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. |
| | 1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. |
| | 1.4. Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. |
| 2. Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх | 2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. |
| | 2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. |
| | 2.3. Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. |
| | 2.4. Шинээр ажлын стандарт гаргах эсэх | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. |
| | 2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болох эсэх | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. |
| 3. Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал | 3.1. Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. |
| | 3.2. Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх, Тухайлбал эмзэг бүлэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. |
| | 3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. |
| 4. Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс | 4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. |
| | 4.2.Төрийн байгууллагын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх | **Тийм** | үгүй | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагаа, мөн иргэдийн төрд итгэх итгэл сайжирна. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| суртахуун | 4.3 Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. |
| | 4.4 Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. |
| | 4.5 Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. |
| 5. Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал | 5.1 Хувь хүн / нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. |
| | 5.2 Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ,агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. |
| | 5.3 Хүмүүсийн амьдралын хэв маяг/ хооллолт, хөлөлгөөн, архи, тамхины хэрэглээ/-т нөлөөлөх эсэх | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. |
| 6. Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем | 6.1 Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх | Тийм | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. |
| | 6.2 Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. |
| | 6.3 Иргэдийн боловсрол / төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага/ олох, мэргэжил эзэмших, давтан сургалтанд хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. |
| | 6.4 Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. |
| | 6.5 Их дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. |
| 7. Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал | 7.1 Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх | Тийм | **Үгүй** | Үйлчилгээний хүртээмж, чанар сайжирснаар гэмт хэргийн гаралт буурч, эерэг нөлөө гарна. |
| | 7.2 Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. |
| | 7.3 Гэмт хэргийн илрүүлэлтэнд нөлөө | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | үзүүлэх эсэх | | | |
| | 7.4 Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. |
| 8. Соёл | 8.1 Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. |
| | 8.2 Хэл, соёлын ялгаатай байдал бий болох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөө үзүүлэх эсэх | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. |

## БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ

*/ Хүснэгт 4/*

| Үзүүлэх үр нөлөө: | Холбогдох асуултууд | Хариулт | | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1.Агаар | 1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. |
| 2. Зам тээврийн түлш, эрчим хүч | 2.1 Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/ бууруулах | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. |
| | 2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. |
| | 2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. |
| | 2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. |
| 3. Ан амьтан, ургамалыг хамгаалах | 3.1. Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх, | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. |
| | 3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. |
| | 3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. |
| | 3.4 Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. |
| 4. Хөрсний бохирдол | 4.1.Газрын дээрхи ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. |
| | 4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. |
| | 4.3. Ундны усны чанарт нөлөөлөх эсэх | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. |
| 5. Хөрсний бохирдол | 5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. |
| | 5.2.Хөрсийг эвдэх , ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. |
| 6. Газрын ашишлалт | 6.1.Ашиглаагүй байсан газрыг ашиглах эсэх | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. |
| | 6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. |
| 7. Нөхөн сэргээгдэх/ нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг/ | 7.1. Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхийг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. |

Хавсралт 2.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг төрөөс нөхөн төлүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулж буй хууль, эрх зүйн актуудын түүвэрлэсэн судалгаа

| № | Хуулийн нэр | Холбогдох зүйл, заалт |
|---|---|---|
| 1 | **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ** | **ХОЁРДУГААР БҮЛЭГ**<br>**ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨ**<br>**Арван зургаадугаар зүйл.**<br>14/Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх эрхтэй. Өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглоно. Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно. Гэм буруутны ял зэмлэлийг түүний гэр бүлийн гишүүд, төрөл саданд нь халдаан хэрэглэхийг хориглоно;<br>**Арван ёсдүгээр зүйл.**<br>1.Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна. |
| 2 | **ЭРҮҮГИЙН ХУУЛЬ** | **ХОЁРДУГААР БҮЛЭГ**<br>**ГЭМТ ХЭРЭГ**<br>**2.5 дугаар зүйл.Гэмт хэргийн хохирол, хор уршиг**<br>1.Энэ хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд шууд учирсан үр дагаврыг гэмт хэргийн хохиролд тооцно.<br>**АРАВДУГААР БҮЛЭГ**<br>**ХҮНИЙ АМЬД ЯВАХ ЭРХИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ**<br>**10.1 дүгээр зүйл.Хүнийг алах**<br>1.Хүнийг алсан бол найман жилээс арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<br>2.Хүнийг:<br>2.1.онц харгис хэрцгийгээр;<br>2.2.олон хүний амь бие, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулж болох аргаар;<br>2.3.захиалгаар;<br>2.4.өөр гэмт хэргийг нуун далдлах, хялбарчлах зорилгоор;<br>2.5.өөртөө, бусдад эдийн, эдийн бус ашигтай байдал |

| | | |
|---|---|---|
| | | бий болгох зорилгоор;<br>2.6.хоёр, түүнээс олон хүнийг;<br>2.7.хохирогчийн биеэ хамгаалж чадахгүй, бага насны хүүхэд, жирэмсэн болохыг мэдсээр байж;<br>2.8.гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж;<br>2.9.эрхэлж байгаа ажил, албан үүрэгтэй нь холбогдуулж өөрийг нь, түүний ойр дотны хүнийг;<br>2.10.зохион байгуулалттай гэмт бүлгийн гишүүн зохион байгуулалттай гэмт үйл ажиллагааныхаа явцад;<br>2.11.бүлэглэж;<br>2.12.эрүүдэн шүүж;<br>2.13.цус, эд, эрхтнийг авах зорилгоор;<br>2.14.үзэл бодол, арьсны өнгө, үндэс, угсаа, шашин шүтлэг, бэлгийн, хүйсийн чиг баримжаагаар нь үзэн ядаж алсан бол арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар нь хорих ял шийтгэнэ.<br>Тайлбар: -Энэ хуульд заасан “бага насны хүүхэд” гэж арван дөрвөн насанд хүрээгүй хүнийг ойлгоно.<br>**АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ**<br>**ХҮНИЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН ХАЛДАШГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ**<br>**11.1 дүгээр зүйл.Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах**<br>1.Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулсан бол арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<br>2.Энэ гэмт хэргийг:<br>2.1.энэ хуулийн 10.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар үйлдсэн;<br>2.2.хохирогчийг тохуурхан доромжилж үйлдсэн;<br>2.3.бие махбодын, сэтгэл санааны шаналал, зовиур үүсгэж үйлдсэн;<br>2.4.зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл хэрэглэсэн;<br>2.5.энэ гэмт хэргийн улмаас хохирогч нас барсан бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<br>Тайлбар: -Энэ хуульд заасан “зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл” гэж иж бүрдэл, бүтцийн хувьд аливаа биетийг устгах, гэмтээх, бие хамгаалах, дохио өгөх зориулалттай эд зүйл, тоног төхөөрөмж, хэрэгслийг хамааруулж ойлгоно. Зэвсэг нь галт, хүйтэн, хийн, үйлдвэрийн, гар хийцийн аль нь ч байж болно. “Тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл” гэж хүний биед гэмтэл, эд хөрөнгөд хохирол учруулахаар тусгайлан бэлтгэсэн, засаж тохируулсан хүйтэн зэвсэг, галт зэвсэг, эд зүйл, хэрэгслийг ойлгоно.<br>**11.4 дүгээр зүйл.Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах**<br>1.Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулсан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл |

| | | |
|---|---|---|
| | | хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.<br>/Энэ хэсэгт 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/<br>2.Энэ гэмт хэргийг:<br>2.1.энэ хуулийн 10.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар;<br>2.2.хохирогчийг тохуурхан доромжилж;<br>2.3.бие махбодын, сэтгэл санааны шаналал, зовиур үүсгэж үйлдсэн бол зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<br>/Энэ заалтад 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/<br>**АРВАН ХОЁРДУГААР БҮЛЭГ**<br>**ХҮНИЙ БЭЛГИЙН ЭРХ ЧӨЛӨӨ, ХАЛДАШГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ**<br>**12.1 дүгээр зүйл.Хүчиндэх**<br>1.Хохирогчийн хүсэл зоригийн эсрэг хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, эсхүл сэтгэцийн өвчтэй, согтуурсан, мансуурсан, сэтгэцийн үйл ажиллагаа нь түр сарнисан, бусад өвчний улмаас биеэ хамгаалах, эсэргүүцэл үзүүлэх чадваргүй, эсхүл эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгааг далимдуулан хүчээр бэлгийн харьцаанд орсон, эсхүл бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийсэн бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<br>2.Энэ гэмт хэргийг:<br>2.1.арван дөрвөөс дээш арван найман насанд хүрээгүй хүнийг хүчиндэж;<br>/Энэ заалтад 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/<br>2.2.бүлэглэж;<br>2.3.гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг хүчиндэж;<br>2.4.хохирогчийг жирэмсэн болгож;<br>2.5.хохирогчид бэлгийн замын халдварт өвчин халдааж;<br>2.6.хоёр, түүнээс олон хүнийг хүчиндэж;<br>2.7.урьд нь энэ бүлэгт заасан гэмт хэргийг үйлдэж гэм буруутайд тооцогдож байсан хүн;<br>2.8.харгис хэрцгий аргаар;<br>2.9.бие махбодын, сэтгэл санааны шаналал, зовиур үүсгэж;<br>/Энэ заалтыг 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/<br>2.10.хохирогчийг тохуурхан доромжилж үйлдсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<br>3.Энэ гэмт хэргийн улмаас ураг зулбасан, эсхүл арван зургаан насанд хүрээгүй хүнийг жирэмсэн болгосон; гэр бүлийн хамаарал бүхий арван зургаан насанд хүрээгүй хүнийг хүчиндсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. |

| | | |
|---|---|---|
| | | 4.Энэ гэмт хэргийг бага насны хүүхдийн эсрэг үйлдсэн; энэ гэмт хэргийн улмаас хохирогч нас барсан бол арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар хорих ял шийтгэнэ.<br>Тайлбар: -Хүчиндэх гэмт хэргийн хохирогч нь бэлгийн халдашгүй байдал нь зөрчигдсөн аль ч хүйсийн хүн байж болно.<br>-Бага насны хүүхдийн эсрэг энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцоход энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан аргаар үйлдсэн байхыг шаардахгүй.<br>-“Бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл” гэж хохирогчийн биеийн аль нэг хэсэгт бэлэг эрхтнээ оруулсан; хохирогчийн бэлэг эрхтэнд өөрийн бусад эрхтэн, эсхүл өөр зүйл оруулсныг ойлгоно.<br>**12.3 дугаар зүйл.Бэлгийн мөлжлөг**<br>1.Хохирогчид хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж; эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгаа байдлыг далимдуулан зорчих эрхийг хязгаарлахгүйгээр бусадтай бэлгийн харьцаанд албадан оруулсан бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<br>2.Энэ гэмт хэргийг хохирогчийн биеийг үнэлүүлж ашиг олох зорилгоор:<br>2.1.арван дөрвөөс арван найман насанд хүрээгүй хүнийг албадан оруулж;<br>/Энэ заалтад 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/<br>2.2.урьд энэ бүлэгт заасан гэмт хэрэг үйлдэж гэм буруутайд тооцогдож байсан хүн;<br>2.3.хохирогчид мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглүүлж;<br>2.4.хохирогчийг жирэмсэн болгож;<br>2.5.хоёр, түүнээс олон хүнийэсрэг;<br>2.6.байнга тогтвортой үйлдсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<br>3.Энэ гэмт хэргийн улмаас:<br>3.1.ураг зулбасан;<br>3.2.арван зургаан насанд хүрээгүй хүнийг жирэмсэн болгосон бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<br>4.Энэ гэмт хэргийг хохирогчийн биеийг үнэлүүлж ашиг олох зорилгоор:<br>4.1.бага насны хүүхдийг албадан оруулж;<br>4.2.зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар хорих ял шийтгэнэ.<br>Тайлбар: -Бага насны хүүхдийн эсрэг энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцоход энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан аргаар үйлдсэн байхыг шаардахгүй.<br>**АРВАН ГУРАВДУГААР БҮЛЭГ**<br>**ХҮНИЙ ХАЛДАШГҮЙ, ЧӨЛӨӨТЭЙ БАЙХ ЭРХИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ**<br>**13.1 дүгээр зүйл.Хүн худалдаалах**<br>1.Биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн |

| | | |
|---|---|---|
| | | мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, эд, эрхтнийг авах, албадан хөдөлмөрлүүлж мөлжих зорилгоор хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, хулгайлж, хууран мэхэлж, итгэл эвдэж, эрх мэдлээ урвуулан ашиглаж, эмзэг байдлыг нь далимдуулж, эсхүл хяналтдаа байлгаж байгаа хүнд төлбөр төлж, хахуульдаж хүнийг эрхшээлдээ оруулан элсүүлсэн; тээвэрлэсэн; орогнуулсан; дамжуулсан; хүлээн авсан бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<br>2.Энэ гэмт хэргийг:<br>2.1.хүүхэд, жирэмсэн эмэгтэйг мэдсээр байж;<br>2.2.хоёр, түүнээс олон хүнийг худалдаалж;<br>2.3.Монгол Улсын хилээр нэвтрүүлж үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<br>3.Энэ гэмт хэргийг:<br>3.1.байнга тогтвортой;<br>3.2.зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар хорих ял шийтгэнэ.<br>Тайлбар: -Хүүхдийн эсрэг энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцоход энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан аргаар үйлдсэн байхыг шаардахгүй.<br>-Энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцоход хохирогч өөрийг нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан аргаар хохироож байгааг өөрөө зөвшөөрсөн эсэх нь гэмт хэргийн зүйлчлэлд нөлөөлөхгүй.<br>**13.2 дугаар зүйл.Хүн хулгайлах**<br>1.Хохирогчид хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, хууран мэхэлж, эсхүл сэтгэцийн өвчтэй, согтуурсан, мансуурсан, сэтгэцийн үйл ажиллагаа нь түр сарнисан, бусад өвчний улмаас биеэ хамгаалах, эсэргүүцэл үзүүлэх чадваргүй байдлыг ашиглаж эрхшээлдээ оруулан авч явсан бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<br>/Энэ хэсэгт 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/<br>2.Энэ гэмт хэргийг:<br>2.1.хүүхэд, жирэмсэн эмэгтэйг мэдсээр байж;<br>2.2.хоёр, түүнээс олон хүнийг хулгайлж;<br>2.3.зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<br>Тайлбар: -Бага насны хүүхдийн эсрэг энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцоход энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан аргаар үйлдсэн байхыг шаардахгүй.<br>**13.3 дугаар зүйл.Хүн барьцаалах**<br>1.Суллах нөхцөл болгон тодорхой үйлдэл хийлгэх, үйлдэл хийхээс түдгэлзүүлэхэд төр, байгууллага, хүнийг албадах зорилгоор болзол тулгаж барьцааны хүнийг алахаар, эрүүл мэндэд хохирол учруулахаар заналхийлж эрхшээлдээ байлгасан бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<br>2.Энэ гэмт хэргийг:<br>2.1.хүүхэд, жирэмсэн эмэгтэйг мэдсээр байж; |

2.2.хоёр, түүнээс олон хүнийг барьцаалж;

2.3.зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар: -Барьцаанд байгаа хүнийг сайн дураараа сулласан хүний үйлдэлд өөр гэмт хэргийн шинжгүй бол түүнийг ялаас чөлөөлнө.

**13.4 дүгээр зүйл.Хүнийг хүчээр алга болгох**

1.Хүнийг хууль бусаар хорьсон нь хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэргийн шинжгүй бол нэг мянга гурван зуун тавин нэгжээс арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх бүхий албан тушаалтан, прокурор, шүүгч хүнийг хууль бусаар хорьсон, хууль бусаар нууж эрх чөлөөг нь хязгаарласан, эсхүл хорьсон, эрх чөлөөг нь хязгаарласан талаархи мэдээллийг нууж, мэдээлэл өгөхөөс татгалзаж эрх чөлөөг нь хязгаарласны улмаас бусдын хууль ёсны эрх, ашиг сонирхолд нь хохирол, хор уршиг учруулсан нь энэ хуулийн тусгай ангид заасан бусад гэмт хэргийн шинжгүй бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3.Энэ гэмт хэргийг:

3.1.хүүхэд, жирэмсэн эмэгтэйг мэдсээр байж;

3.2.хоёр, түүнээс олон хүний эсрэг үйлдсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

4.Энэ гэмт хэргийг:

4.1.зохион байгуулалттай гэмт бүлэг;

4.2.хохирогчийн эрүүл мэндэд хүнд хохирол учруулж үйлдсэн, эсхүл хохирогч нас барсан бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

/Энэ зүйлийг 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

**АРВАН ТАВДУГААР БҮЛЭГ**

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ**

**15.3 дугаар зүйл.Хүний цус, эс, эд, эрхтнийг хууль бусаар авах**

/Энэ зүйлийн гарчигт 2018 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

1.Хууран мэхэлж, эсхүл хүч хэрэглэж, эсхүл хүч хэрэглэхээр заналхийлж хүний цусыг, эсийг авсан бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

/Энэ хэсэгт 2018 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

2.Хууран мэхэлж, эсхүл хүч хэрэглэж, эсхүл хүч хэрэглэхээр заналхийлж хүний эд, эрхтнийг авсан бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3.Энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан гэмт хэргийг хохирогчийн хөрөнгө чинээ, эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлтэй байдал, гэр бүлийн таагүй орчин, амьдрал ахуйн бусад хүнд байдал, биеэ хамгаалж чадахгүй байдлыг далимдуулж эрхшээлдээ байгаа хүний эсрэг үйлдсэн, эсхүл

| | | |
|---|---|---|
| | | энэ гэмт хэргийн улмаас хохирогч нас барсан бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<br>/Энэ зүйлийг 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/<br>**15.5 дугаар зүйл.Хууль бусаар үр хөндөх**<br>1.Эмнэлгийн нөхцөлд жирэмсэн эмэгтэйн амь бие, эрүүл мэндийг хамгаалах зайлшгүй шаардлагыг үндэслэн жирэмслэлтийг зогсоохоос бусад тохиолдолд хохирогчийн хүсэл зоригийн эсрэг жирэмслэлтийг хүчээр таслан зогсоосон бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<br>2.Эх барих, эмэгтэйчүүдийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөлтэй эмч эмнэлгийн бус нөхцөлд; тусгай зөвшөөрөлгүй хүн хууль бусаар үр хөндсөний улмаас хохирогчийн эрүүл мэндэд хүнд хохирол учирсан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<br>3.Энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан гэмт хэргийн улмаас хохирогч нас барсан бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<br>**АРВАН ЗУРГАДУГААР БҮЛЭГ**<br>**ХҮҮХДИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ**<br>**16.1 дүгээр зүйл.Хүүхдийг гэмт хэрэг үйлдэхэд татан оруулах**<br>1.Хүүхдэд амлалт өгч, хууран мэхэлж; хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж; хохирогчийн хөрөнгө чинээ, эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлтэй байдал, гэр бүлийн таагүй орчин, амьдрал ахуйн бусад хүнд байдлыг далимдуулж гэмт хэрэг үйлдэхэд татан оруулсан бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<br>2.Хүүхдийг зохион байгуулалттай гэмт бүлэгт, найман жилээс дээш хугацаагаар хорих ял шийтгэхээр заасан гэмт хэрэг үйлдэхэд татан оруулсан бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<br>**16.3 дугаар зүйл.Хүүхдийг хаях, төөрүүлэх, тэнүүчлэлд хүргэх**<br>1.Хуулиар хүлээсэн асран хамгаалах, харгалзан дэмжих үүргээсээ зайлсхийж хүүхдийг хаясан, орон гэрээ олох боломжгүй газар зориуд орхисон, хүүхдийг оршин суугаа газраас нь хөөж тэнүүчлэхэд хүргэсэн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<br>/Энэ хэсгийг 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн |

хуулиар өөрчлөн найруулсан/

2.Энэ гэмт хэргийн улмаас хохирогчийн эрүүл мэндэд хүнд хохирол учирсан, хохирогч нас барсан бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

**16.5 дугаар зүйл.Хүүхэд солих**

1.Хүүхдийг санаатайгаар сольсон бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

**16.7 дугаар зүйл.Хүүхэдтэй хэрцгий харьцах**

1.Арван найман насанд хүрсэн хүн хүүхдийг аливаа үйлдэл, эс үйлдэхүйн төлөө удаа дараа хэрцгий харьцаж, бие махбодын, сэтгэл санааны шаналал, зовиур үүсгэсэн бол дөрвөн зуун тавин нэгжээс нэг мянга гурван зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас гурван сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.

2.Энэ гэмт хэргийг багш, сурган хүмүүжүүлэгч, асран хамгаалах үүрэг хүлээсэн хүн үйлдсэн бол дөрвөн зуун тавин нэгжээс хоёр мянга долоон зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас зургаан сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.

**16.11 дүгээр зүйл.Хүүхдийг асран хамгаалах үүргээ үл биелүүлэх**

1.Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хуулиар хүлээсэн асран хамгаалах үүргээ биелүүлээгүйн улмаас хүүхдийн эрүүл мэндэд хүндэвтэр хохирол учирсан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.

/Энэ хэсэгт 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

2.Энэ гэмт хэргийн улмаас хүүхдийн эрүүл мэндэд хүнд хохирол учирсан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3.Энэ гэмт хэргийн улмаас хүүхэд нас барсан бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

**АРВАН ДОЛДУГААР БҮЛЭГ**

**ӨМЧЛӨХ ЭРХИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ**

**17.2 дугаар зүйл.Дээрэмдэх**

1.Бусдын эд хөрөнгийг илээр, хүч хэрэглэхгүйгээр, хууль бусаар авсан бол зургаан сараас таван жил хүртэл

| | | |
|---|---|---|
| | | хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<br>/Энэ хэсэгт 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/<br>2.Бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж авахаар довтолсон бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<br>3.Энэ гэмт хэргийг:<br>3.1.байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон;<br>3.2.зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл хэрэглэж үйлдсэн;<br>3.3.зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<br>/Энэ заалтад 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/<br>**АРВАН ЕСДҮГЭЭР БҮЛЭГ**<br>**ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ**<br>**19.3 дугаар зүйл.Төрийн өндөр албан тушаалтны амь биед халдах**<br>1.Монгол Улсын төр, засгийг бусниулан доройтуулах зорилгоор улс төр, төрийн үйл ажиллагаатай нь холбогдуулан төрийн өндөр албан тушаалтны эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулсан бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<br>2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан зорилгоор төрийн өндөр албан тушаалтныг алсан бол арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар нь хорих ял шийтгэнэ.<br>**ХОРИН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ**<br>**ХЭРЭГ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ**<br>**21.12 дугаар зүйл.Эрүү шүүлт тулгах**<br>1.Төрийн албан хаагч тайлбар, мэдүүлэг авах, хэрэг хүлээлгэх, ял, шийтгэл оногдуулах, ялгаварлах зорилгоор өөрөө, эсхүл бусад этгээдийг хатгаж, зөвшөөрөл олгож, эсхүл бусад байдлаар тухайн үйлдлийг хийхийг зөвшөөрч байгаагаа илэрхийлж бусдын бие махбод, сэтгэл санааг шаналган зовоосон бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<br>/Энэ хэсэгт 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/<br>**ХОРИН ЕСДҮГЭЭР БҮЛЭГ**<br>**ХҮН ТӨРӨЛХТНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭНХ ТАЙВНЫ ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ**<br>**29.1 дүгээр зүйл.Түрэмгий дайныг төлөвлөх, бэлтгэх, өдөөх, дэгдээх**<br>1.Түрэмгий дайныг төлөвлөсөн, бэлтгэсэн, эсхүл |

| | | |
|---|---|---|
| | | өдөөсөн бол найман жилээс арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<br><br>2.Түрэмгий дайн дэгдээсэн бол арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар хорих ял шийтгэнэ.<br><br>**29.8 дугаар зүйл.Террорист үйлдэл хийх**<br><br>/Энэ зүйлийн гарчигт 2019 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./<br><br>1.Төр, олон улсын байгууллагаас тодорхой шийдвэр гаргуулах, гаргасан шийдвэрийг өөрчлүүлэх, шийдвэр гаргахаас татгалзуулах зорилгоор галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх, цөмийн бодис, цацраг идэвхт хаягдал, хими, биологийн хортой, аюултай бодис, цахим сүлжээ, техник хэрэгсэл, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйлийг ашиглаж, ашиглахаар заналхийлж хүн амыг айдаст автуулсан; галдан шатаасан, хүн хулгайлсан, хүн, объект барьцаалсан, хүнийг алсан, эрүүл мэндэд хохирол учруулсан; зэвсэгт мөргөлдөөний нөхцөлд сөргөлдөгч аль нэг талд идэвхтэй оролцоогүй хүний амь бие, бие махбодид халдсан хүнийг арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар хорих ял шийтгэнэ. |
| 3 | **ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬ** | **НАЙМДУГААР БҮЛЭГ**<br>**ХОХИРОГЧ, ИРГЭНИЙ НЭХЭМЖЛЭГЧ, ИРГЭНИЙ ХАРИУЦАГЧ**<br>**8.1 дүгээр зүйл.Хохирогч**<br>1.Гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг хохирогч гэнэ.<br>**8.2 дугаар зүйл.Хохирогчийн эрх**<br>1.9.гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийг нэхэмжлэх, нөхөн төлүүлэх хүсэлт гаргах;<br>**8.5 дугаар зүйл.Иргэний нэхэмжлэгч**<br>1.Гэмт хэргийн улмаас учирсан эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирлыг нөхөн төлүүлэх, сэргээлгэхээр шаардлага тавьж байгаа хүн, хуулийн этгээдийг иргэний нэхэмжлэгч гэнэ.<br>2.Гэмт хэргийн улмаас эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээд нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, эсхүл түүний учруулсан эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирлыг хариуцвал зохих этгээдэд холбогдуулан иргэний нэхэмжлэл гаргах эрхтэй бөгөөд тэрхүү нэхэмжлэлийг шүүх уг хэргийн хамт хянан шийдвэрлэнэ. |
| 4 | **ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬ** | **3 дугаар зүйл.Шүүхэд мэдүүлэх эрх**<br><br>3.1.Монгол Улсын хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлоо зөрчигдсөн гэж үзэж байгаа аливаа этгээд уг эрхээ хамгаалуулахаар энэ хуульд заасан журмын дагуу шүүхэд нэхэмжлэл, хүсэлт, гомдол гаргах хэлбэрээр мэдүүлэх эрхтэй. |
| 5 | **ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬ** | **10 дугаар зүйл.Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан**<br><br>10.1.Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан нь Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдэгдсэн, энэ хуулийн |

| | | |
|---|---|---|
| | | 10.3-т заасан гэмт хэргийн улмаас амь насаа алдсан этгээдийн гэр бүлийн гишүүн, хүнд гэмтэл учирсан хохирогчид нөхөн төлбөр олгох зориулалттай байна.<br>10.2.Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангийн хөрөнгө нь энэ хуулийн 6.1.1, 6.1.2-т зааснаас гадна дараах эх үүсвэрээс бүрдэнэ:<br>10.2.1.шүүхээс ногдуулсан торгох ялыг биелүүлж, төсөвт тушаасан мөнгөн хөрөнгийн 60 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгө;<br>10.2.2.шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр энэ хуулийн 10.3-т заасан гэмт хэрэгт гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон этгээдээс хохирол барагдуулсан төлбөр.<br>10.3.Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангийн хөрөнгийг Эрүүгийн хуулийн 10.1 дүгээр зүйл /Хүнийг алах/, 11.1 дүгээр зүйл /Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах/, 11.4 дүгээр зүйл /Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах/, 12.1 дүгээр зүйл /Хүчиндэх/, 12.3 дугаар зүйл /Бэлгийн мөлжлөг/, 13.1 дүгээр зүйл /Хүн худалдаалах/, 13.2 дугаар зүйл /Хүн хулгайлах/, 13.3 дугаар зүйл /Хүн барьцаалах/, 13.4 дүгээр зүйл /Хүнийг хүчээр алга болгох/, 15.3 дугаар зүйл /Хүний цус, эс, эд, эрхтнийг хууль бусаар авах/, 15.5 дугаар зүйл /Хууль бусаар үр хөндөх/, 16.1 дүгээр зүйл /Хүүхдийг гэмт хэрэг үйлдэхэд татан оруулах/, 16.3 дугаар зүйл /Хүүхдийг хаях, төөрүүлэх, тэнүүчлэлд хүргэх/, 16.6 дугаар зүйл /Хүүхэд худалдах/, 16.7 дугаар зүйл /Хүүхэдтэй хэрцгий харьцах/, 16.11 дүгээр зүйл /Хүүхдийг асран хамгаалах үүргээ үл биелүүлэх/, 17.2 дугаар зүйл /Дээрэмдэх/, 19.3 дугаар зүйл /Төрийн өндөр албан тушаалтны амь биед халдах/, 21.12 дугаар зүйл /Эрүү шүүлт тулгах/, 29.1 дүгээр зүйл /Түрэмгий дайныг төлөвлөх, бэлтгэх, өдөөх, дэгдээх/, 29.8 дугаар зүйл /Террорист үйлдэл хийх/-д заасан гэмт хэргийн улмаас амь насаа алдсан этгээдийн гэр бүлийн гишүүн, түүнчлэн хүнд гэмтэл учирсан хохирогчийн шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрт заасан дараах хохиролд нөхөн төлбөр олгоход зарцуулна:<br>10.3.1.эмчилгээний зардал;<br>10.3.2.оршуулгын зардал;<br>10.3.3.хөдөлмөрийн чадвараа алдсанаас дутуу авсан цалин хөлс, түүнтэй адилтгах орлого.<br>10.4.Гэмт хэргийн хохирогчид олгох нөхөн төлбөрийн хэмжээ нь хохирлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэх тухай шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр тодорхойлогдоно.<br>10.5.Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангаас гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох журмыг Засгийн газар батална. |
| 6 | **МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР** | **5.4.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журмыг хангах чиглэлээр:**<br>5.4.8.Төрөөс гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх бодлогын баримт бичгийг баталж, гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг бууруулах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлнэ. |

Хавсралт 3.

“Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг төрөөс нөхөн төлүүлэх хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах” судалгааны ажлын хүрээнд Цагдаагийн байгууллагын100 мөрдөгчөөс авсан анкетын судалгааны үр дүн.

| Асуулт | Тоо | Хувь |
|---|---|---|
| **Таны ажил үүргээ хэрэгжүүлэх явцад ямар төрлийн гэмт хэргийн хохирогч дийлэнхи тохиолдолд хандаж байна вэ? /Гурваас доошгүйг дугуйлна уу./** | | |
| А. Хүний амьд явахын эсрэг гэмт хэрэг | 8 | 8 |
| Б. Хүний эрүүл мэнд халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг | 44 | 44 |
| В. Хүний бэлгийн эрх чөлөөтэй байх эрхийн гэмт хэрэг | 26 | 26 |
| Г. Хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн гэмт хэрэг | 2 | 2 |
| Д. Хүний хувийн, улс төрийн эрх, чөлөөний эсрэг гэмт хэрэг | 10 | 10 |
| Е. Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг | 14 | 14 |
| Ё. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг | 16 | 16 |
| **Тухайн хохирогч болсон иргэдэд гэмт хэргийн улмаас эдийн засгийн хохирол учирсан уу?** | | |
| А. Тийм | 94 | 94 |
| Б. Үгүй | 6 | 6 |
| **Хэрэв тийм бол ямар хэмжээний хохирол дийлэнхи тохиолдолд учирсан бэ?** | | |
| А. 300.000-1.000.000 | 83 | 88.3 |
| Б. 1.000.000-2.000.000 | 6 | 6.3 |
| В. 2.000.000-3.000.000 | 5 | 5.4 |
| **Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг хэрхэн үнэлдэг вэ?** | | |
| А. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч үнэлсэн | 8 | 8 |
| Б. Үнэлгээний байгууллага | 86 | 86 |
| В. Шүүхийн шинжилгээний байгууллага | 6 | 6 |
| Г. Бусад | - | - |
| **Хохирогч нар гэмт хэргийн улмаас учирсан хохирлоо бүрэн авч чадсан уу?** | | |
| А. Тийм | 20 | 20 |
| Б. Үгүй | 80 | 80 |
| **Хэрвээ тийм гэж хариулсан бол хаана/хэн/-с аас авч байна вэ?** | | |
| А. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд | 12 | 60 |
| Б. Шүүхийн шатанд | 2 | 10 |
| В. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага | 6 | 30 |
| Г. Бусад | - | - |
| **Үгүй гэж хариулсан бол?** | | |
| А. Дутуу нөхөн төлүүлсэн | 56 | 70 |
| Б. Огт нөхөн төлүүлж чадаагүй | 20 | 25 |
| В. Бусад | 4 | 5 |
| **Гэмт хэргийн улмаас учирсан эдийн хохирол хохирогчдын санхүүгийн байдалд хэрхэн нөлөө үзүүлж байна уу ?** | | |
| А. Маш их | 54 | 54 |
| Б. Хүндрэлтэй | 40 | 40 |
| В. Бага | 4 | 4 |
| Г. Нөлөө байхгүй | 2 | 2 |
| **Гэмт хэргийн улмаас хохирлыг түргэн шуурай барагдуулах ажиллгаанд таны бодлоор чухам юу саад болж байна вэ?** | | |
| А. Эрх зүйн орчны дутмаг байдал | 12 | 12 |
| Б. Иргэдийн эрх зүйн мэдлэг дутмаг | 50 | 50 |
| В. Эдийн засгийн нөхцөл байдал | 38 | 38 |
| Г. Бусад | - | - |
| **Таны ойр дотны болон найз нөхдийн хүрээнээс гэмт хэргийн хохирогч болж** | | |

| | | |
|---|---|---|
| **байсныг мэдэх үү?** | | |
| А. Хүний амьд явахын эсрэг гэмт хэрэг | 2 | 2 |
| Б. Хүний эрүүл мэнд халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг | 8 | 8 |
| В.Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг | 2 | 2 |
| Г. Хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг | 2 | 2 |
| Д. Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг | - | - |
| Е. Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг | 66 | 66 |
| Ё. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг | 20 | 20 |
| **Та гэмт хэргийн улмаас учирсан хохиролыг төрөөс нөхөн барагдуулж, харин төр гэмт этгээдээс нэхэмжлэх эрх зүйн тогтолцоог дэмжиж байна уу?** | | |
| А. Тийм | 66 | 66 |
| Б. Тодорхой хэмжээнд дэмжиж байна. | 30 | 30 |
| В. Тодорхой хэмжээнд дэмжихгүй байна. | 4 | 4 |
| Г. Огт дэмжихгүй байна. | - | - |
| **Та “гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан” байдаг гэдгийг мэдэх үү?** | | |
| А. Мэднэ | 30 | 30 |
| Б. Мэдэхгүй | 70 | 70 |
| **Хохирогчид энэ сангаар дамжуулан нөхөн төлбөр авч байсан уу?** | | |
| А. Авч байсан | 4 | 4 |
| Б. Авч байгаагүй | 96 | 96 |
| **Хэрэв авч байсан бол гэмт хэргийн улмаас учирсан хохирлоо бүрэн барагдуулан авч чадсан уу?** | | |
| А. 100% | 1 | 25 |
| Б. 80% | - | - |
| В. 50% | 2 | 50 |
| Г. 30% | 1 | 25 |
| Д. 10% | - | - |

Хавсралт 4.

“Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг төрөөс нөхөн төлүүлэх хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах” судалгааны ажлын хүрээнд гэмт хэргийн улмаас хохирсон 400иргэнээс авсан анкетын судалгааны үр дүн.

| Асуулт | Тоо | Хувь |
|---|---|---|
| **Та ямар гэмт хэргийн хохирогч болж байсан бэ?** | | |
| А.Хүний амьд явахын эсрэг гэмт хэрэг | - | - |
| Б.Хүний эрүүл мэнд халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг | 8 | 2 |
| В.Хүний бэлгийн эрх чөлөө,халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг | 8 | 2 |
| Г.Хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг | 40 | 10 |
| Д.Хүний хувийн , улс төрийн эрх , эрх чөлөөны эсрэг гэмт хэрэг | - | - |
| Е.Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг | 160 | 40 |
| Ж.Хөдөлгөөний аюулгүй байдал,тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг | 184 | 46 |
| **Таны хохирогч болсон гэмт хэргийн улмаас эдийн засгийн хохирол учирсан уу?** | | |
| А.Тийм | 352 | 88 |
| Б.Үгүй | 48 | 12 |
| **Хэрэв тийм бол ямар хэмжээний хохирол учирсан бэ?** | | |
| А.300.000-1.000.000 | 264 | 75 |
| Б.1.000.000-2.000.000 | 57 | 16.2 |
| В.2.000.000-3.000.000 | 16 | 4.5 |
| Г.Түүнээс дээш бол бичнэ үү. | 15 | 4.3 |
| **Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэрхэн үнэлсэн бэ?** | | |
| А.Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч үнэлсэн | 128 | 32 |
| Б.Үнэлгээний байгуллага | 240 | 60 |
| В.Шүүхийн шинжилгээний байгууллага | 32 | 8 |
| Г.Бичнэ үү. | - | - |
| **Гэмт хэргийн улмаас учирсан хохирлоо бүрэн авч чадсан уу ?** | | |
| А.Тийм | 96 | 24 |
| Б.Үгүй | 304 | 76 |
| **Хэрвээ тийм гэж хариулсан бол хаана хэнээс авсан бэ?** | | |
| А.Хэрэг бүртгэлт,мөрдөн байцаалтын шатанд | 64 | 66.6 |
| Б.Шүүхийн шатанд | 7 | 7.3 |
| В.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгуулагаас | 20 | 20.8 |
| Г.Бусад | 5 | 5.3 |
| **Үгүй гэж хариулсан бол** | | |
| А.Дутуу нөхөн төлүүлсэн | 161 | 52.9 |
| Б.Огт нөхөн төлүүлж чадаагүй | 143 | 47.1 |
| В.Бусад | - | - |
| **Гэмт хэргийн улмаас учирсан эдийн засгийн хохирол таны санхүүгийн байдалд хэрхэн нөлөө үзүүлж байна вэ?** | | |
| А.Маш их | 100 | 25 |
| Б.Хүндрэлтэй | 240 | 60 |
| В.Бага | 12 | 3 |
| Г.Нөлөө байхгүй | 48 | 12 |
| **Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг түргэн шуурхай барагдуулах ажиллагаанд таны бодлоор чухам юу саад болж байна вэ?** | | |
| А.Эрх зүйн орчны дутмаг байдал | 136 | 34 |
| Б.Иргэдийн эрх зүйн мэдлэг | 104 | 26 |
| В.Хууль,эрх зүйн зөвлөгөө, туслалцаа авч чадахгүй байдал | 160 | 40 |
| Г.Бусад | - | - |

| | | |
|---|---|---|
| **Таны ойр дотны болон найз нөхдийн хүрээнээс гэмт хэргийн хохирогч болж байсныг мэдэх үү ? Ямар гэмт хэргийн хохирогч болж байсан бэ?** | | |
| А.Хүний амьд явахын эсрэг гэмт хэрэг | 8 | 2 |
| Б.Хүний эрүүл мэнд халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг | 40 | 10 |
| Г.Хүний бэлгийн эрх чөлөө , халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг | 24 | 6 |
| Д.Хүний хувийн , улс төрийн эрх, эрх чөлөөны эсрэг гэмт хэрэг | - | - |
| Е.Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг | 144 | 36 |
| Ё.Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг | 120 | 30 |
| Ж.Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг | 64 | 16 |
| **Та гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг төрөөс нөхөн барагдуулж,харин төр гэмт этгээдээс нэхэмжлэх эрх зүйн тогтолцоог дэмжиж байна уу?** | | |
| А.Тийм | 344 | 86 |
| Б.Тодорхой хэмжээнд дэмжиж байна. | 32 | 8 |
| В.Тодорхой хэмжээнд дэмжихгүй байна. | 24 | 6 |
| Г.Огт дэмжихгүй байна. | - | - |
| **Та ‘’Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан”байдгийг мэдэх үү?** | | |
| А.Мэднэ | 56 | 14 |
| Б.Мэдэхгүй | 344 | 86 |
| **Энэ сангаар дамжуулан нөхөн төлбөр авч байсан уу?** | | |
| А.Авч байсан | 1 | 1.7 |
| Б.Авч байгаагүй | 55 | 98.3 |
| **Та авч байсан бол гэмт хэргийн улмаас учирсан хохирлоо бүрэн барагдуулан авч чадсан уу?** | | |
| А.100% | - | - |
| Б.80 хувь | - | - |
| В. 50 хувь | 1 | 100 |
| Г.30 хувь | - | - |
| Д. 10 хувь | - | - |
| **Эрх бүхий албан тушаалтан энэ сангийн үйл ажиллагааны талаар тайлбарлан өгч байсан уу?** | | |
| А.Тийм | - | - |
| Б.Тодорхой хэмжээгээр өгч байсан | 26 | 6.5 |
| В.Үгүй | 374 | 93.5 |